



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



АШУУИС
НИЙГМИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН СУРГУУЛЬ

ХДХВ, ТЭМБҮҮГИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТЫН ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН, 2017 ОН

Улаанбаатар хот
2018 он

Энэхүү судалгааг Глобал сангийн дэмжлэгтэйгээр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран хэрэгжүүлэв.

Судалгааны удирдах зөвлөл:

- Д.Ганцэцэг, ЭМЯ-ны НЭМГ-ын дарга
- Ж.Даваалхам, ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны албаны дарга
- А.Өнөржаргал, ЭМЯ-ны НЭМГ-ын БЗДХ/ДОХ/Сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- С.Энхжин, ЭМЯ-ны ХШҮДАГ-ын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- А.Амарбал, Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга (зөвшилцсөнөөр)
- Б.Цацралт-Од, ХӨСҮТ-ийн халдварт өвчний тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захирал
- Д.Бат-Очир, ХӨСҮТ-ийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны албаны эрдэмтэн нарийн бичгийн дарга
- Б.Цогтбаатар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал
- Х.Ганцэцэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик мэдээллийн албаны дарга
- А.Оюунбилэг, Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн зохицуулагч
- О.Чимэдсүрэн, АШУҮИС-ийн НЭМС-ийн захирал (зөвшилцсөнөөр)
- Ж.Нарантуяа, ДЭМБ-ын ХДХВ, ДОХ-ын асуудал хариуцсан хөтөлбөрийн мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- Д.Болорчимэг, НҮБ-ын Хүүхдийн снагийн ХДХВ, ДОХ-ын асуудал хариуцсан хөтөлбөрийн мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- А.Илиза, НҮБ-ын Хүн амын сангийн ХДХВ, ДОХ-ын асуудал хариуцсан хөтөлбөрийн мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- Х.Ням-Өлзий, Төгс бүсгүйчүүд ТББ-ын гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)
- Г.Эрдэнэтуяа, Хамтдаа ТББ-ын гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)
- Д.Мягмардорж, Залуус эрүүл мэнд ТББ-ын гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)
- Г.Нямпүрэв, Дэмжих төв ТББ-ын гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)

Судалгааны баг:

Үндсэн судлаач

- Д.Нарансүх, АУ-ны доктор, АШУҮИС-ийн багш, НЭМС, тэнхимийн эрхлэгч

Зөвлөх

- О.Чимэдсүрэн, АУ-ны доктор, профессор, АШУҮИС-ийн НЭМС-ийн захирал
- Б.Цацралт-Од, АУ-ны доктор, ХӨСҮТ-ийн дэд захирал
- Ж.Даваалхам, АУ-ны доктор, ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны дарга

Ложистик асуудал хариуцсан зохицуулагч:

- С.Мягмарчулуун, АУ-ны доктор, АШУҮИС-ийн НЭМС-ийн багш
- Э.Эрдэнэтунгалаг, ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны тархвар судлаач
- П.Түмэндэмбэрэл, НЭМ-ийн магистр, ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны тархвар судлаач

А.Улаанбаатар хотын багийн гишүүд

- Ч.Бямбаа Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн мэргэжилтэн
- Б.Гансүх Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн мэргэжилтэн

М.Сэргэлэн	Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн
Б.Оюунбэлэг	хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны ХДХВ, ДОХ-ын ЭТҮ-ний
Б.Жүгдэржав	тасгийн эрхлэгч ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны БЗДХ-ын ЭТҮ-ний тасгийн
Г.Эрдэнэтуяа	эрхлэгч ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны их эмч
Б.Солонго	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны их эмч
О.Энхжаргал	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны их эмч
П.Үнэнчимэг	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны их эмч
Б.Пүрэвдагва	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны их эмч
З.Сэцэн	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны их эмч
П.Нарантуяа	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны их эмч
М.Оюунжаргал	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны тархвар судлаач
Б.Баяндалай	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны сувилагч
А.Ганчимэг	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны сувилагч
Б.Пүрэвсүрэн	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны сувилагч
Ж.Юмчинсүрэн	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны сувилагч
Ц.Ганбаатар	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны сувилагч
Ш.Мягмарсүрэн	ХӨСҮТ-ийн НЛА-ны ДОХ/БЗДХ-ын лабораторийн тасгийн
Ё.Алтанцэцэг	эрхлэгч ХӨСҮТ-ийн НЛА-ны ДОХ/БЗДХ-ын лабораторийн их эмч
Б.Уянга	ХӨСҮТ-ийн НЛА-ны ДОХ/БЗДХ-ын лабораторийн их эмч
Б.Дайриймаа	ХӨСҮТ-ийн НЛА-ны ДОХ/БЗДХ-ын лабораторийн лаборант
Л.Уранчимэг	ХӨСҮТ-ийн НЛА-ны ДОХ/БЗДХ-ын лабораторийн лаборант
Б.Пүрэвсүрэн	ХӨСҮТ-ийн НЛА-ны ДОХ/БЗДХ-ын лабораторийн лаборант
Ж.Соёлмөнх	ХӨСҮТ-ийн НЛА-ны ДОХ/БЗДХ-ын лабораторийн лаборант
Б.Хулан	ХӨСҮТ-ийн НЛА-ны ДОХ/БЗДХ-ын лабораторийн лаборант
Ю.Гантөгс	АШУҮИС-ийн НЭМС-ийн багш
М.Мөнхзаяа	АШУҮИС-ийн НЭМС-ийн багш
Ц.Оюу	АШУҮИС-ийн НЭМС-ийн багш
Ц.Энх-Оюун	АШУҮИС-ийн НЭМС-ийн багш
С.Хандмаа	АШУҮИС-ийн НЭМС-ийн багш
В.Нямцэнгэл	АШУҮИС-ийн АУС-ийн багш
Н.Энхнасан	АШУҮИС-ийн НЭМС-ийн магистрант
Д.Баасанцэрэн	АШУҮИС-ийн НЭМС-ийн магистрант
Х.Ариунболд	АШУҮИС-ийн НЭМС-ийн магистрант
А.Бадралхүү	АШУҮИС-ийн НЭМС-ийн магистрант
Т.Шүрэнцэцэг	МУБИС-ийн Хөтөлбөрийн албаны мэргэжилтэн
Т.Тана-Эрдэнэ	МУБИС-ийн оюутан
Т.Азжаргал	НЭМ-ийн магистр
Х.Цацалмаа	БЗД-ийн ЭМТ-ийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн зохицуулагч
А.Загдсамбар	БЗД-ийн ЭМТ-ийн ДОХ/БЗДХ-ын их эмч
Л.Хулан	БЗД-ийн Өсвөр үе залууст ээлтэй клиникийн их эмч
Л.Ханхүү	БЗД-ийн ЭМТ-ийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн сувилагч
Т.Баасансүрэн	СХД-ийн 22-р хорооны ӨЭМТ-ийн сувилагч
Х.Ням-Өлзий	Төгс бүсгүйчүүд ТББ-ын гүйцэтгэх захирал
Б.Баярмаа	Төгс бүсгүйчүүд ТББ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний
Ч.Эрдэнэчимэг	мэргэжилтэн Төгс бүсгүйчүүд ТББ-ын их эмч
Ө.Энх-Амгалан	Төгс бүсгүйчүүд ТББ-ын кейс менежер

Н.Цэрэндолгор	Төгс бүсгүйчүүд ТББ-ын хүрч очих ажилтан
Г.Эрдэнэсүрэн	Төгс бүсгүйчүүд ТББ-ын хүрч очих ажилтан
М.Дэлгэрзаяа	Төгс бүсгүйчүүд ТББ-ын хүрч очих ажилтан
Д.Мягмардорж	Залуус эрүүл мэнд төв ТББ-ын гүйцэтгэх захирал
Г. Нямпүрэв	Залуус эрүүл мэнд төв ТББ-ын хүрч очих үйл ажиллагаа болон орон нутаг хариуцсан менежер
Э.Янжинлхам	Залуус эрүүл мэнд төв ТББ-ын сэтгэл зүйч
Б.Байгал	Төрийн захиргаа, удирлагын эрх зүйч
Д.Занабазар	Эрх зүйч
Б.Билгүүн	Хуульч
Б.Халиун	Хэвлэлийн дизайнер
Б.Сүхээ	Жолооч
Г.Дэлгэр	Жолооч
М.Баатархүү	Жолооч
Б.Батхуяг	Жолооч

Б.Орон нутгийн багийн гишүүд:

- 1. Дархан-Уул аймаг** Б.Гэрэлмаа, ЭМГ-ын НЭМ-ийн төвийн ДОХ/БЗДХ-ын хөтөлбөрийн эмч
Г.Туул, НЭ-ийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн их эмч
Т.Энхзаяа НЭ-ийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн сувилагч
Я.Оюунцэцэг, НЭ-ийн лабораторийн лаборант
Б.Нарангэрэл, НЭ-ийн лабораторийн лаборант
Ж.Эрдэнэтуяа, Итгэл найдвар эмэгтэйчүүдийн холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал
Б.Мишиг, Жолооч
- 2. Дорнод аймаг** С.Солонго, ЭМГ-ын ДОХ/БЗДХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн
П.Оюумаа, БОЭТ-ийн ДОХ/БЗДХ-ын халдвар судлагч
Н.Цэцэгтуяа, БОЭТ-ийн ДОХ/БЗДХ-ын кабинетын сувилагч
Б.Оюунгэрэл, БОЭТ-ийн лабораторийн лаборант
Д.Бүжин, ЛЭОС ТББ -ын тэргүүн
Д.Батхуяг, Жолооч
- 3. Орхон аймаг** Б.Цэндбаяр, ЭМГ-ын ДОХ/БЗДХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн
Д.Цэвэлмаа, БОЭТ-ийн ДОХ/БЗДХ-ын их эмч
С.Тунгалаг, БОЭТ-ийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн сувилагч
Т.Удвал, БОЭТ-ийн лабораторийн лаборант
Б.Марина, Эрхэмсэг оршихуй Эрдэнэт ТББ-ын төслийн менежер
Б.Мандал, Жолооч
- 4. Хөвсгөл аймаг** З.Жаргалмаа, НЭ-ийн ДОХ/БЗДХ-ын их эмч
Ц.Эрболд, НЭ-ийн ДОХ/БЗДХ-ын их эмч
Н.Жаргалтуяа, НЭ-ийн ДОХ/БЗДХ-ын кабинетийн сувилагч
Т.Оюунчимэг, НЭ-ийн лабораторийн лаборант
О.Ууганцэцэг, Төгс зохицол-Гэр бүл ТББ-ын гүйцэтгэх захирал
Б.Алтансүх, Жолооч

Товчилсон үгийн жагсаалт

АУ	Анагаах ухаан
АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн газар
ЛЭОС	Либераль эмэгтэйчүүдийн оюуны сан
МУ	Монгол улс
МУБИС	Монгол улсын багшийн их сургууль
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
НЛА	Нэгдсэн лабораторийн алба
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НЭ	Нэгдсэн эмнэлэг
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
НЭМГ	Нийгмийн эрүүл мэндийн газар
НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТС	Тандалт судалгаа
ТСА	Тандалт судалгааны алба
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ФХЭБУ	Фермент холбоот эсрэг биеийн урвал
ЭБҮ	Эмэгтэй биеэ үнэлэгч
ЭБЭ	Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭТҮ	Эмчилгээ тусламж үйлчилгээ
НIV	Human infectious virus
RPR	Сийвэнгийн түргэвчилсэн урвал (тэмбүү өвчин илрүүлэх шинжилгээ)
TRNA	Цус наалдуулах урвал (тэмбүүгийн баталгаажуулах шинжилгээ)

Агуулга

ХУРААНГУЙ.....	11
НЭГ. УДИРТГАЛ.....	12
1.1 Судалгааны үндэслэл	12
1.2 Зорилго, зорилт.....	13
ХОЁР. СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ.....	13
2.1 Судалгааны загвар	13
2.2 Судалгааны хүн ам.....	13
2.3 Судалгааны хүрээ ба түүврийн хэмжээ	13
2.4 Мэдээлэл цуглуулах арга, хэрэглэгдэхүүн	17
2.5 Ёс зүйн асуудал	18
2.6 Мэдээлэл цуглуулалт.....	18
2.7 Судалгааны багынханд зориулсан сургалт.....	25
2.8. Судалгааны мэдээлэл боловсруулалт.....	25
ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	25
3.1 ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМЫН БҮЛГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	25
3.1.1 Судалгаанд хамрагдсан хүн амын шинж байдал.....	25
3.1.2 ХДХВ болон тэмбүүгийн халдварын тархалт	28
3.1.3 ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэг	30
3.1.4 Эрсдэлт бүлгийн хүн амын бэлгийн зан үйл.....	32
3.1.5 Эрсдэлт бүлгийнхний дундах согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ.....	41
3.1.6 ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүртээмж, үр нөлөө	42
3.1.7 Хүний эрхийн зарим асуудал	47
3.2 ОЮУТАН ЗАЛУУЧУУДЫН СУДАЛГААНЫ ДҮН	47
3.2.1 Судалгаанд хамрагдсан хүн амын шинж байдал.....	47
3.2.2 ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага.....	50
3.2.3 Бэлгийн зан үйл, дадал	51
3.2.4 Бэлгийн замаар дамжих халдвар.....	57
3.2.5 Архи, согтууруулах ундааны хэрэглээ	58
3.2.6 ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүртээмж	60
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.....	63
ЗӨВЛӨМЖ.....	64
Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан ЭБЭ-ийн үрийн зураглал.....	65
Хавсралт 2. ЭБҮ-ийн дундах ХДХВ-ийн халдвартай байх магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр.....	67

Хавсралт 3. ЭБЭ-ийн дундах ХДХВ-ийн халдвартай байх магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр.....	69
Хавсралт 4. 15-24 насны оюутан залуучуудын дунд ХДХВ-ийн халдвар тархахад нөлөөлөх хүчин зүйл.....	71

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 2.1 Судалгааны хүн амын тодорхойлолт
- Хүснэгт 2.2 Судалгаанд хамрагдах ЭБҮ-ийн түүврийн хэмжээ
- Хүснэгт 2.3 Судалгаанд хамрагдах ЭБЭ-ийн түүврийн хэмжээ
- Хүснэгт 2.4 ЭБЭ-ийн судалгааны үр ба оролцогчдын тоо
- Хүснэгт 2.5 Судалгаанд хамрагдах оюутан залуучуудын түүврийн ерөнхий тооцоо
- Хүснэгт 2.6. Судалгаанд хамрагдах оюутан залуучуудын түүврийн тоо
- Хүснэгт 3.1 Эрсдэлт бүлгийн хүн амын хувийн жин, хүн ам зүйн шинж байдал, сонгосон үзүүлэлтээр
- Хүснэгт 3.2 Эрсдэлт бүлгийн хүн амын хувийн жин, нийгэм эдийн засгийн шинж байдлын сонгосон үзүүлэлтээр
- Хүснэгт 3.3 Тэмбүүгийн халдварын тархалт, эрсдэлтэй бүлгүүдээр, 2017 он
- Хүснэгт 3.4 Тэмбүүгийн халдварын тархалт, эрсдэлтэй бүлгүүдээр, ТС-ны оноор
- Хүснэгт 3.5 Тэмбүүгийн халдварын тархалт, судалгааны хүрээ, ЭБҮ-ийн хувиар
- Хүснэгт 3.6 ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг
- Хүснэгт 3.7 ЭБҮ-ийн бэлгийн зан үйл, хувийн жин болон ТС-ны оноор
- Хүснэгт 3.8 ЭБҮ-ийн үйлчлүүлэгчээ олдог болон биеэ үнэлж буй газар, хувийн жин, 2017 он
- Хүснэгт 3.9 ЭБҮ-ийн бэлгэвчийн хэрэглээ
- Хүснэгт 3.10 ЭБҮ-ийн бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан шалтгаан, хувиар, 2017 он
- Хүснэгт 3.11 БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн болон эмчилгээ хийлгэсэн байдал, ТС-ны оноор
- Хүснэгт 3.12 ЭБЭ-ийн бэлгийн зан үйл, хувийн жингээр, ТС-ны оноор
- Хүснэгт 3.13 ЭБЭ-ийн бэлгийн эрсдэлт зан үйл, хувиар, 2014, 2017 он
- Хүснэгт 3.14 Бэлгийн хавьталд оролцогчдын тоо, ЭБЭ бүлгээр, ТС-ны оноор
- Хүснэгт 3.15 ЭБЭ-ийн бэлгэвчний хэрэглээний түвшин
- Хүснэгт 3.17 БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн болон эмчилгээ хийлгэсэн байдал, ЭБЭ-ийн хувиар, ТС-ны оноор
- Хүснэгт 3.18 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ, эрсдэлт бүлгээр
- Хүснэгт 3.19 Мансууруулах бодисын төрөл болон хэрэглэх хэлбэр, эрсдэлт бүлгээр
- Хүснэгт 3.20 ХДХВ-ийн халдвар илрүүлэх сайн дурын зөвлөгөө шинжилгээнд хамрагдсан байдал, эрсдэлт бүлгээр, 2017 он
- Хүснэгт 3.21 ЭБҮ-ийн ХДХВ-ийн халдвараас сэргийлэх үйлчилгээний хүртээмж
- Хүснэгт 3.22 Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэл, эрсдэлт бүлгээр, 2017 он
- Хүснэгт 3.24 Хэн нэгний нөлөөн дор хүчээр биеэ үнэлж байсан, ЭБҮ-ийн хувийн жингээр, 2017 он
- Хүснэгт 3.23 Хүний эрх, ялгаварлан гадуурхалттай холбоотой гарч байсан бэрхшээлүүд, ЭБЭ, ЭБҮ-ийн хувиар, 2017 он

- Хүснэгт 3.24 Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэл, эрсдэлт бүлгээр,
2017 он
- Хүснэгт 3.25 Хүний эрх, ялгаварлан гадуурхалттай холбоотой гарч байсан
бэрхшээлүүд, ЭБЭ, ЭБҮ-ийн хувиар, 2017 он
- Хүснэгт 3.26 Хэн нэгний нөлөөн дор хүчээр биеэ үнэлж байсан, ЭБҮ-ийн хувийн
жингээр, 2017 он
- Хүснэгт 3.27 Хүн ам зүйн шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд, хүйсээр
- Хүснэгт 3.28 Нийгэм, эдийн засгийн шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд,
хүйсээр
- Хүснэгт 3.29 ХДХВ,ДОХ-ын талаарх мэдлэг, хүйсээр
- Хүснэгт 3.30 ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, суралцдаг сургуулиар
- Хүснэгт 3.31 Халдвар дамжих хамгийн эрсдэлтэй бэлгийн хавьтлын төрөл
- Хүснэгт 3.32 Бэлгийн зан үйл дадал, хүйсээр
- Хүснэгт 3.33 Бэлгийн зан үйл, суралцдаг сургуулиар
- Хүснэгт 3.34 Бэлгийн зан үйл, амьдардаг газраар
- Хүснэгт 3.35 Оюутан залуусын бэлгэвчийн хэрэглээ
- Хүснэгт 3.36 Оюутан залуусын бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан
Шалтгаан
- Хүснэгт 3.37 Оюутан залуусын бэлгийн зан үйлийн талаарх хандлага, хүйсээр
болон сургуулиар
- Хүснэгт 3.38 Оюутан залуусын бэлгийн замаар дамжих халдвар
- Хүснэгт 3.40 Оюутан залуусын архи согтууруулах ундаа, мансууруулах бодисын
хэрэглээ ба бэлгийн зан үйлийн талаарх хандлага, суралцдаг
сургуулиар
- Хүснэгт 3.41 Оюутан залуусын архи согтууруулах ундаа, мансууруулах бодисын
хэрэглээ ба бэлгийн зан үйлийн талаарх хандлага, амьдардаг газраар
- Хүснэгт 3.42 Оюутан залуусын мансууруулах бодисын хэрэглээ
- Хүснэгт 3.43 ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хүйсээр

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 2.1 ЭБҮ-ийг судалгаанд хамруулах байршил-цаг хугацаанд суурилсан түүвэрлэлтийн байршил (Улаанбаатар хотод)
- Зураг 3.1 ЭБҮ-ийн дундах тэмбүүгийн халдварын тархалт, байршлаар
- Зураг 3.2 ЭБЭ-ийн дундах тэмбүүгийн халдварын тархалтын хандлага, ТС-ны оноор
- Зураг 3.3 ЭБЭ-ийн дундах ХДХВ-ийн халдварын тархалтын хандлага, ТС-ын оноор
- Зураг 3.4 ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх хувь
- Зураг 3.5 ХДХВ-ийн халдварт өртөх хамгийн эрсдэлтэй бэлгийн хавьтлыг тодорхойлсон байдал
- Зураг 3.6 Биеэ үнэлж буй гол шалтгаан, ЭБҮ-ийн хувийн жингээр, 2017 он
- Зураг 3.7 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэж, хариугаа авсан хүн амын эзлэх хувь, эрсдэлт бүлгээр, ТС-ны оноор
- Зураг 3.8 Сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан хувь, эрсдэлт бүлгээр, ТС-ны оноор
- Зураг 3.9 ЭБҮ-ийн ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөө, ТС-ны оноор

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

- Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан ЭБЭ-ийн үрийн зураглал
- Хавсралт 2. ЭБҮ-ийн дундах ХДХВ-ийн халдвартай байх магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр
- Хавсралт 3. ЭБЭ-ийн дундах ХДХВ-ийн халдвартай байх магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр
- Хавсралт 4. 15-24 насны оюутан залуучуудын дунд ХДХВ-ийн халдвар тархахад нөлөөлөх хүчин зүйл

ХУРААНГУЙ

Тандалт судалгааг эрсдэл өндөртэй хүн амын бүлгийн дундах Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ын тархалтыг тандан судлах, ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, бэлгийн зан үйлийг судлах зорилгоор хэрэгжүүлэв.

Судалгаанд ХДХВ, БЗДХ-т өртөх эрсдэлтэй хүн амын бүлэг болох эмэгтэй биеэ үнэлэгчид (n=458), эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд (n=261)-ийг хамруулав. Мөн ЭМЯ болон судалгааны удирдах зөвлөлийн зөвлөмжөөр өсвөр үе, залуучуудын төлөөлөл болох 15-24 насны их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнууд (n=1875)-ыг судалгаанд хамруулав.

Эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ)-ийн судалгаанд байршил-цаг хугацаанд суурилсан түүвэрлэлтийн аргыг ашиглаж Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Дорнод, Хөвсгөл аймагт судалгааг явуулав. Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд (ЭБЭ)-ийн судалгаанд хариулагч-чиглүүлсэн түүвэрлэлтийн аргыг ашиглаж Улаанбаатар хотод явуулав. Оюутны судалгаанд УБ хотод байрлах төрийн болон хувийн өмчит их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 15-24 насны оюутнуудыг хамруулав.

ХДХВ, БЗДХ-ын тархалт: Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн дунд тэмбүүгийн халдварын тархалт 24.5 хувь тодорхойлогдсон нь 2014 оны тандалт судалгааны дүнтэй харьцуулахад 4.7 пунктээр буурсан байна. Судалгаа явуулсан бүх байршил (Улаанбаатар хот, аймаг)-д тэмбүүгийн халдварын тархалт 2014 оны үеэс буурсан дүн тодорхойлогдов. ЭБҮ-ийн дунд ХДХВ-ийн халдварын тохиолдол илрээгүй.

ЭБЭ-ийн дунд тэмбүүгийн халдварын тархалт 2014 онд 7.1 хувь байсан бол 2017 онд 9.2 хувь болж нэмэгдсэн байна. ХДХВ-ийн халдварын тархалтын хувь 9.2 болж 2014 оныхоос 2.8 пунктээр буурсан байна.

15-24 насны оюутан, залуучуудын дунд тэмбүүгийн халдварын тархалт 0.6 хувь, ХДХВ-ийн халдварын тохиолдол илрээгүй.

ХДХВ, ДОХ, БЗДХ-ын талаарх мэдлэг: ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн ЭБҮ-ийн хувь 25.3, ЭБЭ-ийн бүлэгт 55.6 хувь 15-24 насны оюутнуудын дунд 21.4 хувь байна.

Бэлгэвчийн хэрэглээ: Сүүлийн 12 сарын хугацаанд төлбөртэй бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч тогтмол хэрэглэсэн ЭБҮ-ийн эзлэх хувь 51.3 байгаа нь 2014 оныхоос 5.6 пунктээр буурсан байна. Төлбөр авахгүй бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч тогтмол хэрэглэдэг ЭБҮ-ийн эзлэх хувь 2014 оныхоос 6.7-оор нэмэгдсэн байна. Түүнчлэн байнгын бэлгийн хавьтагчтайгаа бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэдэг ЭБҮ-ийн хувь 15.6 тодорхойлогдов.

ЭБЭ-ийн дунд сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн хувь 55.9 байгаа нь 2014 оныхоос 10.4 пунктээр нэмэгдсэн байна.

Эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэдэг ЭБЭ-ийн эзлэх хувь 60.2 болж 2014 оны үеэс 15.3 пунктээр нэмэгджээ.

15-24 насны оюутан, залуучуудын дунд бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэдэг хувь 57.4 байсан.

БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн байдал: Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн 41.9 хувьд нь сүүлийн 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн байна. Уг дүнг 2014 оныхтой харьцуулахад 12 пунктээр нэмэгджээ. Шинж тэмдэг илэрсэн ЭБҮ-ийн 57.8 хувь нь БЗДХ-ын шинж тэмдгийн улмаас эмнэлэгт хандсан гэж хариулав.

ЭБЭ-ийн 8.4 хувь нь сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн гэж хариулсан бөгөөд тэдний 54.5 хувь нь улсын болон хувийн эмнэлэгт хандаж эмчилгээ хийлгэсэн гэж хариулсан байна.

15-24 насны оюутан, залуучуудын 6.9 хувьд нь сүүлийн 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн бөгөөд 46.9 хувь нь эмнэлэгт хандаж эмчлүүлсэн байна. Эрэгтэй оюутнуудын 2.8 хувьд нь шинж тэмдэг илэрч 58.3 хувь нь эмчлүүлсэн бол эмэгтэй оюутнуудын 10.5 хувьд нь шинж тэмдэг илэрч, 44.3 хувь нь эмчлүүлсэн байна.

НЭГ. УДИРТГАЛ

1.1 Судалгааны үндэслэл

Энэ удаагийн судалгаа нь эрсдэл өндөртэй хүн амын бүлэг болох ЭБЭ, ЭБҮ, 15-24 насны оюутан, залуучуудын дундах Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), тэмбүүгийн халдварын тархалтыг тандан судлах, ХДХВ, ДОХ, БЗДХ-ын талаарх мэдлэг, хандлага, бэлгийн зан үйлийг судлах зорилготой юм.

Судалгааны үр дүн нь ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх, халдварын тархалтыг тогтоон барих, бууруулахад шаардлагатай үйл ажиллагааг төлөвлөх, ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааг үнэлэх, “Дэлхийн ДОХ-ын асуудлаарх хяналт-шинжилгээний тайлан”, Үндэсний түвшинд хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүдийг тайлагнахад мэдээллийн үндсэн эх сурвалж болдог.

Монгол улсад ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгааг 2002 оноос эхлэн 8 удаа хийгээд байгаа ба 2009 онд судалгааны удирах зөвлөлөөс ХДХВ-ийн халдвар болон БЗДХ-т өртөх эрсдэл багатай бүлгийн хүн амын судалгааг 4 жил тутамд, эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг 2 жил тутамд хийх зөвлөмж гаргасны дагуу 2017 онд эрсдэлт бүлгийг төлөөлүүлэн эмэгтэй бие үнэлэгч (ЭБҮ), эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд (ЭБЭ)-ийг хамруулан судалгааг зохион байгуулсан. Мөн Монгол улсын засгийн газрын мөрийн хөтөлбөртэй холбоотойгоор 15-24 насны оюутан залуучуудыг нийт хүн амын бүлгийн төлөөлөл болгон судалгаанд хамруулсан болно.

1.2 Зорилго, зорилт

Хүн амын тодорхой бүлгүүдийн дундах ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалт, халдварын талаарх мэдлэг, хандлага, зан үйлийн түвшинг тодорхойлох

Зорилт

- Эрсдэлт бүлгийн хүн амын дундах ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтыг тодорхойлох
- Эрсдэлт бүлгийн хүн амын ХДХВ, ДОХ, БЗДХ-ын талаарх мэдлэг, хандлага, бэлгийн зан үйл, түүнд гарч буй өөрчлөлтийг үнэлэх
- 15-24 насны оюутан, залуучуудын дундах ХДХВ, тэмбүүгийн халдварын тархалтыг тодорхойлох
- 15-24 насны оюутан, залуучуудын ХДХВ, ДОХ, БЗДХ-ын талаарх мэдлэг, хандлага, бэлгийн зан үйл, түүнд гарч буй өөрчлөлтийг үнэлэх

ХОЁР. СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

2.1 Судалгааны загвар

Судалгаанд агшингийн загварыг ашиглаж асуумжийн болон лабораторийн шинжилгээгээр мэдээ баримт цуглуулав.

2.2 Судалгааны хүн ам

Судалгаанд ХДХВ-ийн халдвар, БЗДХ-т өртөх эрсдэл өндөртэй бүлэг болох 1) эмэгтэй бие үнэлэгчид, 2) эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд болон нийт хүн амын бүлгийн төлөөлөл болох 3) 15-24 насны оюутан залуучуудыг хамруулав. Судалгааны хүн амын бүлгийн тодорхойлолтыг Хүснэгт 2.1-д харуулав.

Хүснэгт 2.1 Судалгааны хүн амын тодорхойлолт

Хүн амын бүлэг	Тодорхойлолт
Эмэгтэй бие үнэлэгч (ЭБҮ)	Сүүлийн 12 сарын хугацаанд тохиролцсоны үндсэн дээр бэлгийн хавьталд орохдоо мөнгө/бэлэг авсан 15-аас дээш насны эмэгтэйчүүд
Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд (ЭБЭ)	Сүүлийн 12 сарын хугацаанд эрэгтэй хүнтэй шулуун гэдсээр болон амаар бэлгийн хавьталд орсон 15-аас дээш насны эрэгтэйчүүд
Оюутан залуучууд	Их, дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд суралцдаг 15-24 насны оюутан залуус

2.3 Судалгааны хүрээ ба түүврийн хэмжээ

2.3.1 Эмэгтэй бие үнэлэгчид

Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Дорнод, Хөвсгөл аймгуудад ЭБҮ-ийн түүвэрлэлтийг хийв. Түүврийн хэмжээг А.Бүлбүл нарын судалгаа (Улаанбаатар хот дахь эмэгтэй бие үнэлэгчдийн тоо хэмжээ тодорхойлох, зураглал гаргах болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэлэх нь судалгаа, 2015-2016)-гаар тодорхойлсон нөхөн үржихүйн (15-49 нас) насны эмэгтэйчүүдийн дундах ЭБҮ-ийн хувь (0.33%), 2014 оны ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаагаар тогтоосон ЭБҮ-ийн

дундах тэмбүүгийн халдварын тархалтын эмпирик түвшин (29.7%), судалгааны загварын нөлөөнд үндэслэн тооцоолсон (Хүснэгт 2.2). Томьёо 1-ийг ашиглан хийсэн тооцооллоор нийт шаардлагатай түүврийн хэмжээг 455 тооцоологдов.

Томьёо 1:

$$SS = \frac{Z^2 \times p \times (1-p)}{e^2}$$

$$n = \frac{SS}{(1 + \frac{SS-1}{SWs})} \times DEFF$$


Түүвэрлэх арга

Судалгаанд ЭБҮ-ийг сонгохдоо байршил-цаг хугацаанд суурилсан түүвэрлэлтийн аргыг ашиглав (Зураг 1). Түүврийн хүрээ нь тухайн судалгаанд оролцогчдын амьдардаг газар биш судалгааны хугацаанд сонгосон байршилд байх хүн ам байна. Судалгааг эхлэхээс өмнө үндсэн мэдээлэгчийн ярилцлагаар ЭБҮ байж болох бүх байршлын жагсаалтыг гаргаж, түүнээс байршлыг сонгож, тогтоосон түүврийн хэмжээг хангах хүртэл түүвэрлэлтийг хийлээ.

Хүснэгт 2.2 Судалгаанд хамрагдах ЭБҮ-ийн түүврийн хэмжээ

Хамрагдах газар	15-49 насны эмэгтэйчүүд	ЭБҮ-ийн тоо ¹	Итг. түвшин (Z=1.96)	Тэмбүүгийн халдвар илрэх магадлал	Алдааны хязгаар p (±%)	Тооцсон түүврийн тоо (n)	Судалгаанд хамруулсан түүврийн тоо (n)
Улаанбаатар	401,086	1,293	95%	0.29	0.057	202	207
Орхон	28,588	94	95%	0.32	0.064	64	56
Дархан-Уул	27,167	90	95%	0.25	0.050	68	70
Дорнод	20,329	67	95%	0.37	0.074	47	49
Хөвсгөл	35,074	116	95%	0.32	0.063	74	76
Нийт	512,244	1,690				455	458

¹ A.Bulbul, Female sex worker population size estimation, venue mapping health service assessment survey in Ulaanbaatar, Mongolia 2015-2016



Зураг 2.1 ЭБҮ-ийг судалгаанд хамруулах байршил-цаг хугацаанд суурилсан түүвэрлэлтийн байршил (Улаанбаатар хотод)

2.3.2 Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд

2014 оны тандалт судалгааны зөвлөмжийн дагуу Улаанбаатар хотын хүн амаас түүврийн хэмжээг тооцов. А.Бүлбүл нарын судалгаагаар 2015 онд тодорхойлсон нөхөн үржихүйн (15-49 нас) насны эрэгтэйчүүдийн дундах ЭБЭ-ийн эзлэх хувь (0.4%), 2014 оны ХДХВ, БЗДХ-ын тандалт судалгаагаар тодорхойлогдсон ЭБЭ-ийн дундах ХДХВ-ийн халдварын тархалтын түвшин (12%-д үндэслэн түүврийн хэмжээг тооцов (Томьёо 1). Уг тооцооллын дагуу судалгаанд шаардлагатай түүврийн нийт хэмжээг 261 байхаар тодорхойлов (Хүснэгт 2.3).

Хүснэгт 2.3 Судалгаанд хамрагдах ЭБЭ-ийн түүврийн хэмжээ

Хамрагдах газар	15-49 насны эрэгтэйчүүд	Итгэлцэх түвшин (Z=1.96)	ХДХВ-ийн халдвар илрэх магадлал	Алдааны хязгаар (±%)	Түүврийн хэмжээ (n)
Улаанбаатар	365,681	95%	0.12	0.036	261

Түүвэрлэлт

Хариулагч чиглүүлсэн түүвэрлэлтийн аргыг ашиглаж ЭБЭ-ийг сонгосон. Улаанбаатар хот дахь ЭБЭ олон нийтийн дундах бүлгийг тодорхойлж, бүлэг тус бүрээс үр сонгосон. Үр тус бүр өөрийн сүлжээний 3 хүнд судалгаанд оролцохыг хүссэн купон тарааж, уг купоныг авсан хүн судалгаанд хамрагдан цааш нь 3 хүнд купон тараах замаар судалгаанд оролцогчдыг элсүүлэв. Судалгаанд ЭБЭ олон

нийтийн сүлжээнд идэвхтэй 4 оролцогчийг үр болгон сонгож, улмаар хариулагч чиглүүлсэн түүврийн аргаар нийт 261 оролцогчдыг судалгаанд хамруулав. Хүснэгт 2.4-д үр бүрээс судалгаанд хамрагдсан оролцогчдын тоог харуулав. Судалгаанд сонгосон ЭБЭ-ийн үрийн тархалт, сүлжээг хавсралт 1-ээр харуулав.

Хүснэгт 2.4 ЭБЭ-ийн судалгааны үр ба оролцогчдын тоо

Үр	Судалгаанд хамрагдсан оролцогчдын тоо
1	138
2	3
3	21
4	99
Бүгд	261

2.3.3 15-24 насны оюутан залуучууд

Судалгаанд УБ хотод байрлах төрийн болон хувийн өмчит их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 15-24 насны оюутнуудыг хамруулсан. Түүврийн хэмжээг тооцоход МУ-ын нийт оюутнуудыг төлөөлөх чадвартай байхаар тооцож, М.Бүрнээ нарын судалгаагаар 2016 онд тодорхойлогдсон оюутнуудын дундах тэмбүүгийн халдварын тархалтын түвшин (2.6%)-г ашиглав. Судалгааны алдааны хязгаар 0.010 байхаар тооцож, түүврийн нийт хэмжээг 1873 байхаар тодорхойлов (Хүснэгт 2.5).

Хүснэгт 2.5 Судалгаанд хамрагдах оюутан залуучуудын түүврийн ерөнхий тооцоо

	15-24 насны оюут- нуудын нийт тоо	Итгэлцэх түвшин	Тэмбүүгийн халдвар илрэх магадлал	Алдааны хязгаар (±%)	Түүврийн хэмжээ
Эрэгтэй	65.612	95%	0.026	0.010	782
Эмэгтэй	91.526	95%	0.026	0.010	1091
Нийт	157.138	95%			1873

Түүвэрлэлт

Судалгаанд санамсаргүй түүвэрлэлтийн аргаар оролцогчдыг сонгоно. Түүвэрлэлтийг хийхдээ Дээд боловсролын статистикт бүртгэгдсэн төрийн болон хувийн өмчит их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудын тоог харгалзав (Хүснэгт 2.6).

Хүснэгт 2.6. Судалгаанд хамрагдах оюутан залуучуудын түүврийн тоо

Оюутны харьяалал	Төрийн өмчийн ИДС	Хувийн өмчийн ИДС	Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв	Нийт		
				Тоо	Хувь	
Улаанбаатар	320	232	47	599	32.0%	
Архангай	66	19	7	92	4.9%	
Баян-Өлгий	16	13	0	29	1.5%	
Баянхонгор	38	22	3	63	3.4%	
Булган	42	11	0	53	2.8%	
Говь-Алтай	36	10	0	46	2.5%	
Говьсүмбэр	14	5	1	20	1.1%	
Дархан-Уул	30	16	1	47	2.5%	
Дорноговь	27	22	5	54	2.9%	
Дорнод	42	12	2	56	3.0%	
Дундговь	18	7	2	27	1.4%	
Завхан	35	9	4	48	2.6%	
Орхон	66	35	3	104	5.5%	
Өвөрхангай	70	26	5	101	5.4%	
Өмнөговь	34	13	0	47	2.5%	
Сүхбаатар	42	8	2	52	2.8%	
Сэлэнгэ	46	23	3	72	3.8%	
Төв	49	16	4	69	3.7%	
Увс	32	21	3	56	3.0%	
Ховд	64	27	2	93	5.0%	
Хөвсгөл	57	22	7	86	4.6%	
Хэнтий	43	14	3	60	3.2%	
Бүгд	Тоо	1,187	583	104	1,874	100.0%
	Хувь	63%	31%	6%	100%	

2.4 Мэдээлэл цуглуулах арга, хэрэглэгдэхүүн

Судалгаанд мэдээлэл цуглуулахад асуумжийн хуудас болон лабораторийн шинжилгээг ашиглав.

Асуумж

Судалгааны үр дүнг өмнөх тандалт судалгаатай харьцуулах зорилгоор ижил асуумжуудыг ашиглав. Судалгааны бүлэг бүрд зориулан боловсруулсан дараах бүтэцтэй асуумжийн хуудсыг мэдээ баримт цуглуулалтад хэрэглэв. Үүнд:

- Хүн ам зүйн мэдээлэл
- Нийгэм эдийн засгийн шинж байдал
- Бэлгийн зан зүйлийн мэдээлэл
- Согтууруулах ундааны хэрэглээ
- Мансууруулах бодисын хэрэглээ
- ХДХВ, ДОХ, БЗДХ-ын талаарх мэдлэг, хандлага, зан үйл
- ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ, үйлчилгээнд хамрагдах байдал
- Хүний эрхтэй холбоотой асуултууд

Судалгаанд ашиглах асуумжууд:

- ЭБҮ-ийн асуумж
- ЭБЭ-ийн асуумж
- Оюутан залуучуудын асуумж

Судалгааны бүртгэлийн хуудас болон асуумжийг цахим хэлбэр лүү хөрвүүлж хөдөлгөөнт интернет холболт, байршил тогтоогч бүхий Таблетыг ашиглаж мэдээлэл цуглууллаа. Бүртгэлийн хуудас, асуумжийн мэдээллийг интернетэд суурилсан дата санд хадгална. Таблетын GPS тохиргоог ашиглаж мэдээлэл цуглуулсан байршлыг тэмдэглэж, судалгааны хяналт, оролцогчдын байршлыг тодорхойлоход ашиглав.

2.5 Ёс зүйн асуудал

Судалгааны аргачлалыг АШУҮИС-ийн НЭМС-ийн Эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, ЭМЯ-ны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2017 оны 11 сарын 7-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж судалгааны ёс зүйн зөвшөөрөл авсны үндсэн дээр судалгааны мэдээлэл цуглуулалтыг эхлүүллээ. Оролцогчдод таниулсан зөвшөөрлийн хуудсаар мэдээлэл өгч танилцуулж, судалгаанд хамрагдахыг урив. Улмаар судалгаанд оролцохыг зөвшөөрсөн хүмүүсийг судалгаанд хамруулав.

2.6 Мэдээлэл цуглуулалт

2.6.1 Мэдээлэл цуглуулах зохион байгуулалтын ажил

Судалгааны зорилтот бүлгийнхэнд “Таниулсан зөвшөөрлийн хуудас”-ны дагуу судалгааны зорилго, ач холбогдол болон хийгдэх үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, судалгаанд оролцохыг урив. Улмаар судалгаанд оролцохыг зөвшөөрсөн оролцогчдыг судалгаанд хамруулав.

Судалгааны зорилго зорилтын дагуу ЭБҮ, ЭБЭ, 15-24 насны оюутан залуучуудаас мэдээлэл цуглуулах гурван баг ажиллаа.

А. Эмэгтэй биеэ үнэлэгчдээс мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулах баг Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Орхон, Хөвсгөл аймгуудад ажиллав. ЭБҮ-ээс мэдээлэл цуглуулах багийг Төгс бүсгүйчүүд ТББ-ын гүйцэтгэх захирал ложистик зохицуулалтаар хангаж ахлан ажиллав. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулав. Үүнд:

Багийн бүрэлдэхүүн: Улаанбаатар хотод судалгааны 3 баг ажиллана. Судалгааны нэг багт ярилцлага авагч 2, сувилагч 1, жолооч 1, хүрч очих ажилтан 1, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байв.

Дархан-Уул, Орхон, Дорнод, Хөвсгөл аймгуудад тус бүр судалгааны нэг дэд багууд ажиллав. Дэд багийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн ДОХ/БЗДХ-ын кабинетын их эмч ахалж ажиллах бөгөөд ярилцлага авагч 1, сувилагч 1, жолооч 1, хүрч очих ажилтан 1, нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй байв.

ЭБҮ-ээс мэдээлэл цуглуулахад багийн ахлагч (1), ТББ-аас ажиллах зохицуулагч (1), орон нутгийн дэд багийн ахлагч (4), хүрч очих ажилтан (7), ярилцлага хийх судлаач (10), сорьц цуглуулах сувилагч (7), орон нутагт шинжилгээ хийх лаборант,

эмч (8), жолооч (7) нараас бүрдсэн нийт 45 хүнтэй баг ажиллаа.

Түүвэрлэлт: ЭБҮ нарт хүрч үйлчилдэг ТББ-тай хамтран түүвэрлэлтийн хүрээг тодорхойлно. ЭБҮ-ийн байршлын жагсаалтад (зочид буудал, баар, массажны газар, шөнийн клуб г.м), байршил бүрд байж болох биеэ үнэлэгчдийн тоог гаргав. Зарим байршилд ЭБҮ-тэй ажилладаг байгууллагуудын зохион байгуулсан үйл ажиллагааны үеэр оролцогчдыг элсүүлж, судалгаанд хамруулав.

Баг бүр судалгаанд хамрагдах ЭБҮ-ийн дугаарыг тухайн багт оногдсон дугаараас эхлүүлэн (001...; 101...; 201...; 301... г.м) үргэлжлүүлэн тооцов.

Ярилцлага хийх: Таниулсан зөвшөөрлийн хуудсаар судалгааны мэдээллийг танилцуулж зөвшөөрөл авсны дараагаар судалгаанд оролцогчидтой ганцаарчилсан ярилцлага хийнэ. Ярилцлага хийх судлаач мэдээлэл цуглуулах үйл явцыг доорх дарааллын дагуу явуулав. Үүнд:

1. Ярилцлага хийх судлаач оролцогчдод судалгааны зорилгыг тодорхой тайлбарлан мэдээлэл өгч, таниулсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулна.
2. Судалгаанд оролцогчдын бүртгэлийн мэдээллийг таблетад суурилуулсан “Бүртгэлийн хуудас”-нд оруулна. Оролцогч татгалзсан тохиолдолд “судалгаанд оролцохоос татгалзсан” тэмдэглэгээг сонгож бүртгэнэ.
3. Судалгаанд оролцохыг зөвшөөрсөн оролцогчдод таблет ашиглан асуумжид хариулах зааврыг өгнө.
4. Оролцогчтой асуумжийн дагуу “Бэлгийн зан үйлийн асуумж”-ийг ярилцлага авагч сурвалжлагын аргаар ганцаарчилсан орчинд асууж ярилцана.
1. Асуумжийн дугаар бүхий “Шинжилгээнд сорьц өгөх бичиг”-ийг оролцогчид өгч цусны дээж авах сувилагч руу илгээнэ. Ярилцлага авагч оролцогчийн хариулсан асуумжийн дугаартай ижил дугаар бүхий гараар бичсэн бүртгэлийн хуудсыг сувилагчид өгнө.
5. Сувилагч оролцогчийн хураагуур судаснаас 5-7 мл цусыг вакуумтейнер ашиглан стандарт аргачлалын дагуу авна. Вакуумтейнер дээрх дугаарыг бүртгэлийн хуудсан дээр наана. Сорьцны дугаар, асуумжийн дугаартай ижил байна. Шинжилгээнд хангалттай хүрэлцэхүйц хэмжээний цус авах ба гемолиз болсон, хэт их липемик сорьцыг шинжилгээнд ашиглахгүй.
6. Ярилцлага хийж, цусны сорьц авсны дараа судалгаанд оролцогчид талархал илэрхийлж, бэлгэвч сурталчилгааны материал өгнө.
7. Улаанбаатар хотод тухайн өдөр цуглуулсан бүх цусны сорьцыг ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны шинжилгээний өрөөнд хадгалан, маргааш өглөө нь ХӨСҮТ-ийн Нэгдсэн Лабораторийн Албаны ДОХ/БЗДХ-ын лабораторид хүргэнэ. Шинжилгээний хариуг ажлын 5 өдөрт багтаж судалгааны баг хүлээн авна.
8. Орон нутагт цуглуулсан бүх сорьцыг тухайн өдөрт нь багтаан шинжилгээний бичгийн хамт харьяа лабораторид сувилагч хүргэнэ. Багийн ахлагч шинжилгээний хариу, асуумжийн хуудаснуудыг Улаанбаатарт байрших судалгааны зохицуулагч руу илгээнэ.
9. Орон нутгаас цуглуулсан сорьцны 10%-ийг ХӨСҮТ-ийн Нэгдсэн

Лабораторийн Албаны БЗДХ-ын лабораторид хүргүүлж, давтан шинжлүүлнэ.

10. Судалгаанд оролцогч шинжилгээгээр тэмбүү эсвэл ХДХВ-ийн халдвартай нь тогтоогдвол эргэн холбогдож үнэ төлбөргүй эмчилгээнд хамруулна.
11. Оролцогч хүсвэл шинжилгээний хариуг авч болох ба шинжилгээний хариу авах карт олгоно. Уг картанд оролцогчийн код, шинжилгээний хариу авах газрын хаяг, утас байна. Шинжилгээний хариуг ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-аас авна. Сувилагч оролцогчоос шинжилгээний хариу гарсан тухай сануулах шаардлагатай эсэхийг асууж, оролцогч хүсвэл утасны дугаарыг нь лабораторийн шинжилгээний бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ. Оролцогчийн нууцлалыг хадгалахын тулд оролцогчийн утасны дугаарыг судалгааны үр дүн, тайлан зэрэг бусад олон нийтэд нээлттэй мэдээлэлд оруулахгүй.

Б. Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүдээс мэдээлэл цуглуулалт
ЭБЭ бүлгийн судалгаанд Улаанбаатар хотоос мэдээлэл цуглуулав. Мэдээлэл цуглуулах багийн судалгааны ложистик зохицуулагч ахлан ажиллаж зохион байгуулалт, мэдээлэл цуглуулах ажлыг хариуцав. ЭБЭ нарт хүрч ажилладаг ТББ-аас ажиллах зохицуулагч ЭБЭ нарын бүлгийг тодорхойлох, үр сонгох, судалгаанд оролцогчдыг элсүүлэх ажлыг хариуцан ажиллав.

Мэдээлэл цуглуулах багийн бүрэлдэхүүн: ЭБЭ-ээс мэдээлэл цуглуулахад багийн ахлагч 1, зохицуулагч 1, купон менежер 1, ярилцлага авагч 5, туслах ажилтан 1, сувилагч 1 нийт 10 хүнээс бүрдсэн баг ажиллана.

Түүвэрлэлт: ЭБЭ-д хүрч үйлчилдэг гурван төрийн бус байгууллага (Хамтдаа, Залуус эрүүл мэнд, Хүний эрх-Залуучууд-Эрүүл мэндийг дэмжих төв)-тай хамтран олох, хүрэхэд хүндрэлтэй, нуугдмал хүн амыг судалгаанд хамруулахад хэрэглэдэг хариулагч чиглүүлсэн түүвэрлэлтийн аргаар ЭБЭ нарыг олно. Улаанбаатар хотод илрүүлсэн ЭБЭ бүлгээс 4 үрийг сонгоно. Үр тус бүр өөрийн сүлжээний 3 хүнд судалгаанд оролцохыг урьсан купон тараана. Купон авсан хүн судалгаанд хамрагдан, цааш 3 хүнд купон тараах замаар судалгааны түүврийн хэмжээнд хүрэхүйц оролцогчдыг судалгаанд хамруулна. Хэрэв эхний сонгосон 4 үр цааш 2-3 оролцогчийг судалгаанд элсүүлээгүй тохиолдолд дахин шинээр үр сонгох шаардлагатай болно.

Ярилцлага: Судалгаанд мэдээлэл цуглуулах ярилцлагыг тусгайлан бэлтгэсэн байранд зохион байгуулна. Судалгаанд оролцохоор ирсэн хүмүүст ярилцлага хийх судлаач Таниулсан зөвшөөрлийн хуудсын дагуу судалгааны зорилго, ач холбогдлыг тодорхой тайлбарлаж мэдээлэл өгнө. Сайн дурын үндсэн дээр судалгаанд хамруулна. Судалгаанд мэдээлэл цуглуулах ажлыг дараах байдлаар явуулна. Үүнд:

1. Ярилцлага хийх судлаач оролцогчдод судалгааны зорилгыг тодорхой тайлбарлан мэдээлэл өгч, таниулсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулна.
2. Судалгаанд оролцогчдын бүртгэлийн мэдээллийг таблетад суурилуулсан

“Бүртгэлийн хуудас”-нд оруулна. Оролцогч татгалзсан тохиолдолд “судалгаанд оролцохоос татгалзсан” тэмдэглэгээг сонгож бүртгэнэ.

3. Судалгаанд оролцохыг зөвшөөрсөн оролцогчдод Таблет ашиглан асуумжид хариулах зааврыг өгнө.
4. Оролцогчтой асуумжийн дагуу *“Бэлгийн зан үйлийн асуумж”*-ийг ярилцлага авагч сурвалжлагын аргаар ганцаарчилсан орчинд асууж ярилцана.
2. Ярилцлага авагч асуумжийн дугаар бүхий *“Шинжилгээнд сорьц өгөх бичиг”*-ийг оролцогчид өгч цусны сорьц авах сувилагч руу илгээнэ. Ярилцлага авагч оролцогчийн хариулсан асуумжийн дугаартай ижил дугаар бүхий гараар бичсэн бүртгэлийн хуудсыг сувилагчид өгнө.
5. Сувилагч оролцогчийн хураагуур судаснаас 5-7 мл цусыг вакуумтейнер ашиглан стандарт аргачлалын дагуу авна. Вакуумтейнер дээрх дугаарыг бүртгэлийн хуудсан дээр наана. Сорьцны дугаар, асуумжийн дугаартай ижил байна. Шинжилгээнд хангалттай хүрэлцэхүйц хэмжээний цус авах ба гемолиз болсон, хэт их липемик сорьцыг шинжилгээнд ашиглахгүй.
6. Ярилцлага хийж, шинжилгээнд цусны сорьц авсны дараагаар судалгаанд оролцогчид талархал илэрхийлж, бэлгэвч, сурталчилгааны материал өгнө.
7. Цуглуулсан бүх сорьцыг тухайн өдөрт нь багтаан шинжилгээний бичгийн хамт ХӨСҮТ-ийн Нэгдсэн Лабораторийн Албаны ДОХ/БЗДХ-ын лабораторид хүргэнэ. Шинжилгээний хариуг ажлын 5 өдөрт багтаж судалгааны баг хүлээн авна.
8. Лабораторийн шинжилгээгээр судалгаанд оролцогчоос халдвар илэрвэл ДОХ/БЗДХ-ын ТСА-ны эмч рүү илгээж, үнэ төлбөргүй эмчилгээнд хамруулна.
9. Оролцогч хүсвэл шинжилгээний хариуг авч болох ба шинжилгээний хариу авах карт олгоно. Уг картанд оролцогчийн код, шинжилгээний хариу авах газрын хаяг, утас байна. Шинжилгээний хариуг ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-аас авна. Сувилагч оролцогчоос шинжилгээний хариу гарсан тухай сануулах шаардлагатай эсэхийг асууж, оролцогч хүсвэл утасны дугаарыг нь лабораторийн шинжилгээний бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ. Оролцогчийн нууцлалыг хадгалахын тулд оролцогчийн утасны дугаарыг судалгааны үр дүн, тайлан зэрэг бусад олон нийтэд нээлттэй мэдээлэлд оруулахгүй.

В. Оюутнуудаас мэдээлэл цуглуулалт

Оюутан залуучуудаас мэдээлэл цуглуулах ажлыг Улаанбаатар хотод явуулна. Багийн ахлагчаар ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны тархвар судлаач ажиллав.

Мэдээлэл цуглуулах багийн бүрэлдэхүүн: Мэдээлэл цуглуулах баг 3 багт хуваагдаж ажиллав. Нэг багт ярилцлага авагч 3, туслах ажилтан 1, сувилагч 1 нийт 5 хүн ажиллах ба мэдээлэл цуглуулах нийт 3 баг ажиллав.

Түүвэрлэлт: Судалгаанд УБ хотод байрлах төрийн, хувийн өмчит их дээд сургууль болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудыг хамрууллаа. Мэдээлэл цуглуулах баг их дээд сургууль, коллеж болон оюутны байрнуудад очиж

оюутнуудыг судалгаанд урьж, түүврийн хэмжээнд хүрэхүйц оролцогчдыг судалгаанд хамруулав.

Ярилцлага: Судалгаанд оролцогчдод судлаач Таниулсан зөвшөөрлийн хуудсын дагуу судалгааны зорилго, ач холбогдлыг тодорхой тайлбарлаж мэдээлэл өгнө. Сайн дурын үндсэн дээр оролцогчийн зөвшөөрлөөр судалгаанд хамруулав. Судалгаанд мэдээлэл цуглуулах ажлыг дараах байдлаар явуулна. Үүнд:

3. Ярилцлага хийх судлаач оролцогчдод судалгааны зорилгыг тодорхой тайлбарлан мэдээлэл өгч, таниулсан зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулна.
4. Судалгаанд оролцогчдын бүртгэлийн мэдээллийг таблетад суурилуулсан "Бүртгэлийн хуудас"-нд оруулна. Оролцогч татгалзсан тохиолдолд "судалгаанд оролцохоос татгалзсан" тэмдэглэгээг сонгож бүртгэнэ.
5. Судалгаанд оролцохыг зөвшөөрсөн оролцогчдод Таблет ашиглан асуумжид хариулах зааврыг өгнө.
6. Оролцогчтой асуумжийн дагуу "Бэлгийн зан үйлийн асуумж"-ийг ярилцлага авагч сурвалжилгын аргаар ганцаарчилсан орчинд асууж ярилцана..
7. Ярилцлага авагч асуумжийн дугаар бүхий "Шинжилгээнд сорьц өгөх бичиг"-ийг оролцогчид өгч цусны сорьц авах сувилагч руу илгээнэ. Ярицлага авагч оролцогчийн хариулсан асуумжийн дугаартай ижил дугаар бүхий гараар бичсэн бүртгэлийн хуудсыг сувилагчид өгнө.
8. Сувилагч оролцогчийн хураагуур судаснаас 5-7 мл цусыг вакуумтейнер ашиглан стандарт аргачлалын дагуу авна. Вакуумтейнер дээрх дугаарыг бүртгэлийн хуудсан дээр наана. Сорьцны дугаар, асуумжийн дугаартай ижил байна. Шинжилгээнд хангалттай хүрэлцэхүйц хэмжээний цус авах ба гемолиз болсон, хэт их липемик сорьцыг шинжилгээнд ашиглахгүй.
9. Ярилцлага хийж, шинжилгээнд цусны сорьц авсны дараагаар судалгаанд оролцогчид талархал илэрхийлж, бэлгэвч, сурталчилгааны материал өгнө.
10. Цуглуулсан бүх сорьцыг тухайн өдөрт нь багтаан шинжилгээний бичгийн хамт ХӨСҮТ-ийн Нэгдсэн Лабораторийн Албаны ДОХ/БЗДХ-ын лабораторид хүргэнэ. Шинжилгээний хариуг ажлын 5 өдөрт багтаж судалгааны баг хүлээн авна.
11. Лабораторийн шинжилгээгээр судалгаанд оролцогчоос халдвар илэрвэл ДОХ/БЗДХ-ын кабинетын эмч рүү илгээж, үнэ төлбөргүй эмчилгээнд хамруулна.
12. Оролцогч хүсвэл шинжилгээний хариуг авч болох ба шинжилгээний хариу авах карт олгоно. Уг картанд оролцогчийн код, шинжилгээний хариу авах газрын хаяг, утас байна. Шинжилгээний хариуг ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-аас авна. Сувилагч оролцогчоос шинжилгээний хариу гарсан тухай сануулах шаардлагатай эсэхийг асууж, оролцогч хүсвэл утасны дугаарыг нь лабораторийн шинжилгээний бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ. Оролцогчийн нууцлалыг хадгалахын тулд оролцогчийн утасны дугаарыг судалгааны үр дүн, тайлан зэрэг бусад олон нийтэд нээлттэй мэдээлэлд оруулахгүй.

Асуумжийн хуудсаар мэдээлэл цуглуулахад анхаарах зүйлс: Судалгаанд оролцогчдоос Бэлгийн зан үйлийн талаар мэдээллийг цуглуулахдаа судалгааны баг дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Судалгааны асуумжийн дагуу ярилцлага авагч судалгаанд оролцогчоос сурвалжилгын аргаар асууж ярилцана.
-
- Асуумжийг бөглөх үед судалгаанд оролцогчийн ганцаарчилсан байдлыг бүрэн хангана.
-
- Судалгааны багийн ахлагч илэрсэн дутагдлыг цаг алдалгүй залруулах ажлыг хариуцан гүйцэтгэж, протокол хөтөлнө.
- Судалгаанд оролцохоос татгалзсан хүний бүртгэлийн хуудсыг тусад нь хадгалж, багийн ахлагчид хүлээлгэж өгнө. Татгалзсан оролцогчийн бүртгэлийн дугаарыг хэвээр үлдээж дараагийн оролцогчийг үргэлжлүүлэн дугаарлана.
- Бүртгэлийн хуудас, асуумжийн дугаар, шинжилгээний хуудсын дугаар бүгд тохирч байх ёстой.

Судалгаанд хамрагдагсдын эмчилгээ: Лабораторийн шинжилгээгээр тэмбүү, ХДХВ-ийн халдвар илэрсэн тохиолдолд судалгаанд оролцогчидтой холбогдож мэдээлнэ. ХӨСҮТ-өөс халдвартай судалгаанд оролцогч болон бэлгийн хавьтагч нарт үнэ төлбөргүйгээр эмчилгээ хийж, зохих зөвлөгөөг өгнө.

2.6.2 Лабораторийн шинжилгээ

Цусны сорьц цуглуулах: ХДХВ болон тэмбүүгийн халдварын ийлдэс судлалын шинжилгээнд стандарт аргачлалаар хураагуур судаснаас цус авч шинжилгээнд хэрэглэв.

Хадгалалт болон тээвэрлэлт: Цусны шинжлэгдэхүүнийг авсан өдөртөө багтаан “Сорьц, шинжлэгдэхүүн хадгалах, тээвэрлэх журам”-ыг баримтлан харьяа ийлдэс судлалын лабораторид хүргэв. Судалгаанд оролцогчдоос авсан цусыг тасалгааны хэмд дөрвөн цагаас доошгүй хугацаагаар байлгасны дараа центрфугт нэг минутад 3000 удаа эргүүлэх хурдаар эргүүлж ийлдсийг ялгаж авна. Улаан эсийг ялгасан ийлдсийг ийлдэс хадгалах гурван саванд (эппиндорф) савлав. Нэг савтай ийлдсийг шинжилгээнд хэрэглэж, 2 дах савтай ийлдсийг -2-8 хэмд, 3 дах савтай ийлдсийг -20 хэмд хөлдөөж хадгална. Орон нутагт ЭБҮ-ээс цуглуулсан цусны ийлдсийн 2 дахь савтай /(-2)-(-8) хэмд хадгалсан/шинжлэгдэхүүнийг 21 хоног тутамд “Сорьц шинжлэгдэхүүн хадгалах, тээвэрлэх журам”-ыг баримтлан ХӨСҮТ-ийн Нэгдсэн Лабораторийн Албаны ДОХ/БЗДХ-ын лабораторид ирүүлнэ. Үлдсэн 3 дахь савтай ийлдсийг ХӨСҮТ-ийн Нэгдсэн Лабораторийн Албаны ДОХ/ БЗДХ-ын лабораторийн хариу иртэл өөрийн лабораторид хадгална.

Сорьц цуглуулах, шинжилгээ хийхэд дараах асуудлыг анхаарна. Үүнд:

- Ийлдэс судлалын шинжилгээнд ЭБҮ, ЭБЭ, 15-24 насны оюутан залуучуудыг хамруулна.
- Шинжилгээний бичгийн дугаар, сорьц бүхий вакумтейнерын дугаар нь асуумжийн дугаартай тохирч байх. Лабораторийн шинжилгээний дүнг тусгай

маягтын дагуу бүртгэнэ.

- Зөвхөн судалгааны аргачлалд заагдсан, төвөөс илгээсэн оношлуурыг ашиглан шинжилгээг хийнэ.
- Оношлуурын зарцуулалтын бүртгэл хөтлөнө.
- ХДХВ-ийн халдвар илрүүлэх хурдавчилсан шинжилгээгээр эерэг гарсан тохиолдлыг тусгай бүртгэлд бүртгэн ХӨСҮТ-ийн НЛА-ны ДОХ/БЗДХ-ын лабораторид илгээж оношийг баталгаажуулна. Онош батлагдсан тохиолдолд үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгална.

ХДХВ-ийн халдвар илрүүлэх: Орон нутагт ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд Abon HIV 1/2-ийг хэрэглэх ба энэ шинжилгээ нь хүний ийлдэс дэх ХДХВ-1 ба ХДХВ-2-т өвөрмөц бүх изотипийн эсрэг биеийг илрүүлэх чадвартай. Уг шинжилгээний хариу эерэг гарсан шинжлэгдэхүүнийг “Биоаюултай илгээмж, биобэлдмэлийг тээвэрлэх журам”-ыг баримтлан ХӨСҮТ-ийн Нэгдсэн Лабораторийн Албаны ДОХ/БЗДХ-ын лабораторид илгээж баталгаажуулсан.

Хурдавчилсан шинжилгээгээр эерэг гарсан шинжлэгдэхүүнийг бүртгэж судалгааны багийн ахлагчид мэдээлнэ. ХӨСҮТ-ийн Нэгдсэн Лабораторийн Албаны ДОХ/БЗДХ-ын лаборатори нь эерэг гарсан ийлдсийг ЭМС-ын 2017 оны 305 тоот тушаал “Бэлгийн замаар дамжих халдвар, Хүний дархлал хомсдолын вирус, Дархлалын олдмол хомсдолын тусламж үйлчилгээний заавар”-ын дагуу ФХЭБУ (ELISA), иммуноблотын арга (Western blot)-аар шинжилгээ хийж оношийг баталгаажуулав. Шинжилгээг хийхдээ оношлуурын үйлдвэрлэгчийн зааврыг баримталсан.

Тэмбүүгийн халдвар илрүүлэх: Орон нутагт тэмбүүгийн халдварын ийлдэс судлалын шинжилгээнд ийлдсийн уургийн түргэн урвалын сорил (RPR), цайвар спирохетийг илрүүлэх цус наалдуулах урвал (TRHA)-ыг ашиглана. Чанарын RPR шинжилгээг үйлдвэрлэгчийн зааврын дагуу RPR шинжилгээний цомог (New Market Laboratories Ltd. Kentford, Newmarket, CB8 & PN-UK) ашиглан хийж тухайн өдрийн багц шинжилгээ бүрт эерэг болон сөрөг хяналтын шинжлэгдэхүүнийг шинжлэн чанарыг баталгаажуулна. RPR шинжилгээ эерэг тохиолдолд чанарын шинжилгээ хийх үйлдвэрлэгчийн зааврын дагуу TRHA цомог (New Market Laboratories Ltd. Kentford, Newmarket, CB8 & PN-UK) ашиглан шинжилгээг хийнэ. RPR болон TRHA-ийн хариу хоёулаа эерэг, RPR-ын шингэрүүлэлт >1:2 үед тэмбүүгийн халдварын тохиолдол гэж үзнэ.

Чанарын хяналт: Лабораторийн шинжилгээний явцад стандартын дагуу дотоод хяналт хийх бөгөөд ирүүлсэн бүх эерэг шинжлэгдэхүүнд, санамсаргүй түүврийн аргаар сонгосон сөрөг шинжлэгдэхүүний 10%-д ХӨСҮТ-ийн Нэгдсэн Лабораторийн Албаны ДОХ/БЗДХ-ын лабораторит чанарын хяналт хийх ба хяналтын шинжилгээнд нэг үйлдвэрийн оношлуур (RPR, TRHA-ийн шинжилгээг тэмбүүгийн цайвар спирохетийн эсрэг бие илрүүлэхэд, ХДХВ-ийн халдварыг илрүүлэхэд иммунохроматографын шинжилгээ) ашиглана.

2.7 Судалгааны багынханд зориулсан сургалт

Судалгаа эхлэхээс өмнө судалгааны багийнханд зориулсан дараах гурван төрлийн сургалтыг зохион байгуулна.

1. ЭБҮ бүлгээс судалгаанд мэдээлэл цуглуулах арга зүйн сургалт
2. ЭБЭ бүлгээс судалгаанд мэдээлэл цуглуулах арга зүйн сургалт
3. 15-24 насны оюутан залуучуудаас судалгаанд мэдээлэл цуглуулах арга зүйн сургалт

Сургалтаар судалгааны зорилго, зорилт, үндсэн аргачлал, зорилтот бүлгүүдийг сонгох, тэдгээрээс мэдээ цуглуулж, ярилцлага хийх арга зүй, нууцлал хадгалах зэрэг сэдвүүдийг хамруулав. Түүнчлэн, хариулагч чиглүүлсэн түүвэрлэлт, байршил-цаг хугацаанд суурилсан түүвэрлэлт, зураглал гаргах талаар заах сургалт хийв.

2.8. Судалгааны мэдээлэл боловсруулалт

Судалгаанд оролцогчдын бүртгэл, асуумж судалгааны мэдээллээр интернетэд суурилсан дата сан үүсгэнэ. Дата санг MS Office Excel өргөтгөлтэй файл руу хөрвүүлж, дата файлын сан үүсгэнэ. Дата файлыг цэвэрлэж, хянаж, бэлтгэсний дараагаар STATA программ руу хөрвүүлж статистик боловсруулалт хийв.

Дата файлд статистик боловсруулалт хийхэд судалгаанд оролцогчдын үл хамаарах хувьсагч (ХДХВ, тэмбүүгийн халдвар)-ийг хамаарах хувьсагчдаас хамааруулан тархалтын түвшинг тодорхойлж, 95%-ийн итгэлцэх түвшин хязгаарт тооцов.

Эрсдэлт бүлгүүдийн хүн амын ХДХВ, ДОХ, БЗДХ-ын тлаарх мэдлэг, хандлага, бэлгийн зан үйл, түүнд гарч буй өөрчлөлтийг үнэлэхдээ энгийн тайлбар статистикийн аргаар үзүүлэлтийн давтамж, дундаж, хувь харьцааг тооцсон.

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1 ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМЫН БҮЛГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Судалгаанд хамрагдсан хүн амын шинж байдал

ХДХВ-ийн халдвар, БЗДХ-т өртөх эрсдэлтэй хүн амын бүлгийн төлөөлөл болох 458 ЭБҮ, 261 ЭБЭ нарыг судалгаанд хамруулав. Эдгээр бүлгийн хүн ам зүйн шинж байдлын сонгосон үзүүлэлтийг Хүснэгт 3.1-д харуулав. Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн дундаж нас 30.8, ЭБЭ-ийнх 28 байв. ЭБҮ-ийн 50% нь 24-36, ЭБЭ-ийн 50% нь 21-35 насныхан байлаа. ЭБҮ-ийн 78% нь гэрлээгүй эсвэл хамтран амьдрагчгүй байсан бол ЭБЭ-ийн 59.8% нь гэр бүлгүй эсвэл хамтран амьдрагчгүй байна. Судалгаанд хамрагдсан эрсдэлт бүлгийн хүн амын дундаж насыг 2014 оны судалгааны дүнтэй харьцуулахад ЭБҮ-ийн хувьд 0.8, ЭБЭ-д 2.4 насаар бага байна (Хүснэгт 3.1).

Хүснэгт 3.1 Эрсдэлт бүлгийн хүн амын хувийн жин, хүн ам зүйн шинж байдал, сонгосон үзүүлэлтээр

Хүн ам зүйн шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд	ХДХВ-ийн халдварт өртөх эрсдэлтэй бүлэг			
	ЭБҮ		ЭБЭ	
	Ерөнхий	Жинлэсэн (95% ИХ)	Ерөнхий	Жинлэсэн (95% ИХ)
Насны бүлэг				
15-24	25.2	28.6 (26.4-30.8)	51.0	51.4 (48.8-54.0)
25-34	45.7	53.0 (50.6-55.4)	23.4	23.6 (21.4-25.8)
35-44	18.9	12.4 (10.8-14.0)	18.0	18.1 (16.1-20.1)
45 ба түүнээс дээш	9.3	6.0 (4.9-7.1)	6.9	6.9 (5.6-8.2)
Насны дундаж/голч нас	30.8/29.0	29.2/28.0	28/24	28/24
Гэрлэлтийн байдал				
Гэрлэсэн	9.8	11.4 (9.9-12.9)	6.9	6.9 (5.6-8.2)
Гэрлээгүй	44.1	48.5 (46.1-50.9)	53.3	53.3 (50.7-55.9)
Хамтран амьдрагчтай	11.1	10.6 (9.1-12.1)	33.3	33.3 (30.9-35.7)
Бэлэвсэн	4.6	3.1 (2.3-3.9)	1.1	1.1 (0.6-1.6)
Салсан	29.3	26.0 (23.9-28.1)	5.4	5.4 (4.2-6.6)
Хариулахгүй	1.1	0.4 (0.1-0.7)	0.0	0.0
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Хариулагчдын тоо	458.0	1660.0	261	1464.0

Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн 16.2% нь тусгай дунд болон дээд боловсролтой хүмүүс эзэлж байсан нь ЭБЭ бүлгийн (54.8%)-хээс 3.4 дахин бага байна. Энэ үзүүлэлтийг 2014 оны тандалт судалгааныхтай харьцуулахад ЭБҮ бүлэгт 2.6, ЭБЭ бүлэгт 5.4 пунктээр нэмэгдсэн байна.

Тусгай дунд болон дээд боловсролтой ЭБЭ, ЭБҮ нарын хувь нэмэгдсэнтэй холбоотойгоор бүрэн, бүрэн бус дунд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь ЭБҮ нарын дунд 5.4, ЭБЭ нарын дунд 5.0 пунктээр буурсан байна.

ЭБҮ нарын дунд бага боловсролтой болон боловсрол эзэмшээгүй гэж хариулсан хувь 10.1 байсан нь 2014 оны судалгааны дүнгээс 2.9 пунктээр их байна (Хүснэгт 3.2).

Хүснэгт 3.2 Эрсдэлт бүлгийн хүн амын хувийн жин, нийгэм эдийн засгийн шинж байдлын сонгосон үзүүлэлтээр

Нийгэм-эдийн засгийн шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд	ХДХВ-ийн халдварт өртөх эрсдэлтэй бүлэг			
	ЭБҮ		ЭБЭ	
	Ерөнхий	Жинлэсэн (95% ИХ)	Ерөнхий	Жинлэсэн (95% ИХ)
Боловсролын түвшин				
Боловсролгүй	3.1	1.6 (1.0-2.2)	0.0	0.0
Бага боловсрол	7.0	3.5 (2.6-4.4)	0.0	0.0
Бүрэн бус дунд боловсрол	17.2	12.0 (10.4-13.6)	2.7	2.7 (1.9-3.5)
Бүрэн дунд боловсрол	56.6	62.9 (60.6-65.2)	42.5	42.5 (40.0-45.0)
Техник мэргэжил/ тусгай дунд	4.6	3.6 (2.7-4.5)	5.0	5.0 (3.9-6.1)
Их, дээд боловсрол	11.6	16.4 (14.6-18.2)	49.8	49.8 (47.2-52.4)
Ажил эрхлэлтийн байдал				
Ажил эрхэлдэггүй	76.6	76.3 (74.3-78.3)	14.6	14.6 (12.8-16.4)
Ажил эрхэлдэг	11.4	12.1 (10.5-13.7)	35.6	35.6 (33.1-38.1)
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	6.3	6.8 (5.6-8.0)	20.3	20.3 (18.2-22.4)
Суралцдаг	4.4	4.0 (3.1-4.9)	27.6	27.6 (25.3-29.9)
Хариулахгүй	0.4	0.5 (0.2-0.8)	0.4	0.4 (0.1-0.7)
Бусад	0.9	0.3 (0.0-0.6)	1.5	1.5 (0.9-2.1)
Бүгд	100	100	100	100
Хариулагчдын тоо	458	1660	261	1464

Эрсдэлт бүлгийнхний ажил эрхлэлтийн байдлыг судлахад ЭБҮ-ийн 76.6% нь биеэ үнэлэлтээс өөр ажил эрхэлдэггүй гэж хариулав. Тэдний 18.2% нь ямар нэг байгууллагад ажилладаг эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 4.4% нь суралцдаг байна.

ЭБЭ-ийн 35.6% нь ажил эрхэлдэг, 20.3% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 14.6% нь ажилгүй гэж хариулав. Тэдний 27.6% нь суралцдаг гэж хариулсан нь ЭБҮ бүлгийнхээс илүү хувьтай байна.

Эрсдэлт бүлгийнхний дунд аль нэг байгууллагад ажилладаг, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүний хувийг 2014 оны тандалт судалгааны дүнтэй харьцуулахад ЭБҮ бүлэгт 2.8, ЭБЭ бүлэгт 2.2 пунктээр буурсан байна. Оюутнуудын эзлэх хувь ЭБҮ нарын дунд 5.4 пунктээр буурч, ЭБЭ нарын дунд 0.5 пунктээр нэмэгдсэн байна (Хүснэгт 3.2).

3.1.2 ХДХВ болон тэмбүүгийн халдварын тархалт

ХДХВ болон тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд нийт 458 ЭБҮ, 261 ЭБЭ хамрагдсан. Шинжилгээгээр ЭБҮ-ийн 24.5%, ЭБЭ-ийн 9.2%-д нь тэмбүүгийн халдвар илрэв (Хүснэгт 3.3).

Хүснэгт 3.3 Тэмбүүгийн халдварын тархалт, эрсдэлтэй бүлгүүдээр, 2017 он

Эрсдэлтэй бүлэг	Шинжилгээ өгсөн хүний тоо	Халдвар илэрсэн хүний тоо	Тэмбүүгийн халдварын тархалтын хувь (95% их)	
			Ерөнхий	Жинлэсэн
Эмэгтэй биеэ үнэлэгч	458	112	24.5%	23.6% (21.6-25.6)
Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд	261	24	9.2%	9.2% (7.7%-10.7%)

Эрсдэлт бүлгийнхний дундах тэмбүүгийн халдварын тархалтыг 2014 оны судалгааны дүнтэй харьцуулахад ЭБҮ-ийн дунд 5.2 пунктээр буурч, ЭБЭ-ийн дунд 2.1 пунктээр нэмэгдсэн байна (Хүснэгт 3.4).

Хүснэгт 3.4 Тэмбүүгийн халдварын тархалт, эрсдэлтэй бүлгүүдээр, ТС-ны оноор

Эрсдэлтэй бүлэг	Тандалтын судалгаа хийгдсэн онууд					
	2005	2007	2009	2011	2014	2017
ЭБҮ	-	-	18.3% (15.7-20.9)	27.5% (24.3-30.7)	29.7% (26.3-33.1)	24.5% Жинлэсэн 23.6% (21.6-25.6)
ЭБЭ	22.0% (10.5-33.5)	11.0% (5.4-16.7)	5.4% (1.8-9.0)	4.1% (1.3-6.9) Жинлэсэн 3.4% (1.7-6.7)	7.1% (3.9-10.3) Жинлэсэн 6.4% (1.2-11.6)	9.2% (5.7%-12.7%) Жинлэсэн 9.2% (7.7%-10.7%)


ЭБЭ-ийн дундах тэмбүүгийн халдварын тархалт 2005 онд хамгийн их буюу 22% байснаа 2011 онд 4.1% хүртэл буурсан. Улмаар 2014 онд 7.1%, 2017 онд 9.2% болж нэмэгджээ. ЭБҮ-ийн дундах тэмбүүгийн халдварын тархалт 2009 онд 18.3% байснаа 2014 онд 29.7% болж нэмэгдсэн бол 2017 онд 24.5% болж буурсан байна (Хүснэгт 3.4).

Тэмбүүгийн халдварын тархалтыг байршлаар нь харьцуулахад Дорнод аймгаас судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн дунд хамгийн их (34.0%), Дархан-Уул аймагт хамгийн бага (11.6%) тархалттай байна. Тэмбүүгийн халдварын тархалт Дорнод аймаг дахь ЭБҮ-ийн дунд өндөр байсан нь 2011, 2014 оны судалгаагаар мөн адил тодорхойлогдож байжээ. ЭБҮ-ийн дундах тэмбүүгийн халдварын тархалтыг 2014 оны судалгааны дүнтэй харьцуулахад бүх байршлуудад буурсан байна.

Хүснэгт 3.5 Тэмбүүгийн халдварын тархалт, судалгааны хүрээ, ЭБҮ-ийн хувиар


ЭБҮ-ийн судалгааны хүрээ	Тандалтын судалгаа		
	2011	2014	2017
ЭБҮ (судалгааны бүх газарт)	27.5%	29.7%	24.5%
ЭБҮ, Улаанбаатар, Дархан-Уул	31.8%	27.7%	18.1%
ЭБҮ, Улаанбаатар	30.5%	28.6%	21.3%
ЭБҮ, Дархан-Уул	36.0%	25.2%	11.6%
ЭБҮ, Дорнод, Орхон, Хөвсгөл	24.7%	33.7%	30.6%
ЭБҮ, Дорнод	31.0%	37.2%	34.0%
ЭБҮ, Орхон	21.0%	31.9%	30.0%
ЭБҮ, Хөвсгөл	22.0%	31.6%	28.8%

Тэмбүүгийн халдварын тархалтын бууралт Дархан-Уул аймагт хамгийн их буюу 13.6 пунктээр, Улаанбаатар хотод 7.3, Дорнод аймагт 3.2, Хөвсгөл аймагт 2.9, Орхон аймагт 1.9 пунктээр тус тус буурсан байна (Хүснэгт 3.5). Тандалт судалгаанд хамрагдсан аймгууд дахь ЭБҮ-ийн дундах тэмбүүгийн тархалтын хувийг зураг 3.1-оор харуулав.




Зураг 3.1 ЭБҮ-ийн дундах тэмбүүгийн халдварын тархалт, байршлаар

ЭБЭ-ийн дундах тэмбүүгийн халдварын тархалт 2005 оноос хойш 2011 хүртэл буурах хандлагатай байснаа 2014 болон 2017 онуудад нэмэгдэх хандлагатай болжээ. 2014 онд тэмбүүгийн халдварын тархалт 7.1% тодорхойлогдсон бол 2017 онд 9.2% болж нэмэгдсэн байна (Зураг 3.2).



Зураг 3.2 ЭБЭ-ийн дундах тэмбүүгийн халдварын тархалтын хандлага, ТС-ны оноор

Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн дунд ХДХВ-ийн халдварын тохиолдол илрээгүй. ЭБЭ-ийн дундах ХДХВ-ийн халдварын тархалт 9.2% байв. ЭБЭ-ийн дундах ХДХВ-ийн халдварын тархалтыг тандалт судалгаа хийгдсэн оноор харьцуулан Зураг 3.3-д үзүүлэв. ХДХВ-ийн халдвар 2005 онд илрээгүй, 2007 онд 0.85% байснаас 2014 онд 12% болж нэмэгдсэн. 2017 оны тандалт судалгаагаар ХДХВ-ийн халдварын тархалт 9.2% (95% ИХ: 8.7-9.7) жинлэсэн үзүүлэлтээр 9.1% (95% ИХ: 8.4.-9.7) болж өмнөх судалгааны дүнгээс 2.8 пунктээр буурсан байна (Зураг 3.3).



Зураг 3.3 ЭБЭ-ийн дундах ХДХВ-ийн халдварын тархалтын хандлага (жинлэсэн дундаж үзүүлэлт), ТС-ын оноор

3.1.3 ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэг


Судалгаанд хамрагдсан эрсдэлт бүлгийнхэн дунд ХДХВ-ийн халдварын талаарх мэдлэгийг судалсан дүнг Хүснэгт 3.6-д харуулав.

Хүснэгт 3.6 ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг

ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг	ХДХВ-ийн халдварт өртөх эрсдэлтэй бүлэг			
	ЭБҮ		ЭБЭ	
	2017	Жинлэсэн (95% ИХ)	2017	Жинлэсэн (95% ИХ)
ХДХВ, ДОХ-ын талаар сонсож байсан	97.8	98.0 (97.3-98.7)	95.4	95.4 (94.3-96.5)
Бэлгийн үнэнч нэг хавьтагчтай байснаар ХДХВ-ийн халдвар дамжих эрсдлийг бууруулна	84.1	79.9 (78.0-81.8)	81.2	81.2 (79.2-83.2)
Бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвчийг хэрэглэснээр ХДХВ-ийн халдвараас сэргийлж чадна	91.1	89.5 (88.0-91.0)	91.6	91.6 (90.1-93.0)
ХДХВ-ийн халдвар дамжихаас сэргийлэх аргуудыг мэддэг хүн амын эзлэх хувь	79.9	92.8 (91.6-94.0)	80.1	80.0 (78.0-82.0)
Гаднаас нь харахад эрүүл хүн ХДХВ-ийн халдвартай байж болно	70.5	74.4 (72.3-76.5)	75.1	75.1 (72.9-77.3)
ХДХВ-ийн халдвар шумууланд хазуулахад дамжихгүй	46.9	40.2 (37.8-42.6)	61.3	61.3 (58.8-63.8)
ХДХВ-ийн халдвартай хүнтэй гар барих, хоол хүнсээ хувааж идэхэд ХДХВ-ийн халдвар дамжихгүй	71.7	72.7 (70.6-74.8)	88.5	88.5 (86.9-90.1)

ХДХВ-ийн халдвар дамжих замын талаар зөв ойлголттой хүн амын эзлэх хувь	39.5	48.8 (46.4-51.2)	53.2	53.2 (50.6-55.8)
ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх хувь	25.3		55.6	55.6 (53.1-58.1)

ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх хувийг 2014 оны тандалт судалгааны дүнтэй харьцуулахад ЭБҮ бүлэгт 25.3% болж 8.1 пунктээр буурсан, ЭБЭ бүлэгт 55.6% болж 0.7 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 3.4).



Зураг 3.4 ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх хувь


ЭБҮ-ийн дундах ХДХВ-ийн халдвараас сэргийлэх мэдлэгийг судалсан дүнг судалгааны байршлаар харьцуулан доорх хүснэгтэд харуулав. Үүнээс харахад ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн ЭБҮ-ийн эзлэх хувь УБ хотод 21.3, Дархан-Уул аймагт 50%, Дорнод аймагт 24.5%, Хөвсгөл аймагт 22.4%, Орхон аймагт 16.1% байв.

Хүснэгт 3.7 ЭБҮ бүлгийн ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэгийн түвшин /байршлаар/

ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг	Судалгааны байршил					Дундаж
	Дархан-Уул	Дорнод	Хөвсгөл	Орхон	УБ	
ХДХВ, ДОХ-ын талаар сонсож байсан	100	97,9	97.4	96.4	98.1	97.8
Бэлгийн үнэнч нэг хавьтагчтай байснаар ХДХВ-ийн халдвар дамжих эрсдэлийг бууруулна	97.1	97.9	80.3	84.7	77.3	84.1
Бэлгийн хавьталд орох бүртгээ бэлгэвчийг хэрэглэснээр ХДХВ-ийн халдвараас сэргийлж чадна	97.1	97.9	92.11	87.5	88.4	91.1
ХДХВ-ийн халдвар дамжихаас сэргийлэх аргуудыг мэддэг хүн амын эзлэх хувь	95.7%	98.0%	77.6%	82.1%	70.5%	79.9

Гаднаас нь харахад эрүүл хүн ХДХВ-ийн халдвартай байж болно	64.3	44.9	81.6	62.5	76.8	70.5
ХДХВ-ийн халдвар шумуулд хазуулахад дамжихгүй	81.4	61.2	39.5	41.1	36.2	46.9
ХДХВ-ийн халдвартай хүнтэй гар барих, хоол хүнсээ хувааж идэхэд ХДХВ-ийн халдвар дамжихгүй	95.7	77.5	53.9	53.6	73.9	71.7
ХДХВ-ийн халдвар дамжих замын талаар зөв ойлголттой хүн амын эзлэх хувь	50.0%	24.5%	27.6%	16.1%	25.6%	39.5
ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх хувь	50.0%	24.5%	22.4%	16.1%	21.3%	25.3

Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн ихэнх (67.1) хувь нь ХДХВ-ийн халдвар авах хамгийн эрсдэлтэй бэлгийн хавьтлын төрлийг үтрээгээр бэлгийн хавьталд орох гэж хариулсан бол ЭБЭ-ийн ихэнх (76.6%) нь шулуун гэдсээр бэлгийн хавьталд орох гэж хариулсан байна (Зураг 3.5).



Зураг 3.5 ХДХВ-ийн халдварт өртөх хамгийн эрсдэлтэй бэлгийн хавьтлыг тодорхойлсон байдал

3.1.4 Эрсдэлт бүлгийн хүн амын бэлгийн зан үйл

А. ЭБҮ-ийн бэлгийн зан үйл

Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн анх бэлгийн хавьталд орсон дундаж нас 18.2 байгаа нь 2014 оны судалгааны дүнтэй ижил байна. Анх биеэ үнэлж эхэлсэн дундаж нас 2014 оны судалгаагаар 24.3 байсан бол 2017 онд 25.1 болж 0.8 насаар нэмэгдсэн байна.

Хүснэгт 3.8 ЭБҮ-ийн бэлгийн зан үйл, хувийн жин болон ТС-ны оноор

Үзүүлэлтүүд	Тандалт судалгаа			Жинлэсэн (95% ИХ)
	2011	2014	2017	
Анх бэлгийн хавьталд орсон нас				
16 нас хүртэл	6.9	7.5	4.7	12.9 (11.3-14.5)
16-20 нас	79.2	80.2	75.1	77.4 (75.4-79.4)
20 ба түүнээс дээш	13.9	12.2	20.2	9.7 (8.3-11.1)
<i>Анх бэлгийн хавьталд орсон насны дундаж</i>	<i>18</i>	<i>18.1</i>	<i>18.2</i>	<i>18.3</i>
<i>Анх биеэ үнэлж эхэлсэн насны дундаж</i>	<i>-</i>	<i>24.3</i>	<i>25.1</i>	<i>24.8</i>
Бүгд	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	753	743	450	1660
Сүүлийн 7 хоногт бэлгийн хавьталд орсон хүний тоо				
4 хүртэл	58.6	61.2	51.5	50.3 (47.9-52.7)
4 ба түүнээс дээш	41.4	38.8	48.5	49.7 (47.3-52.1)
<i>Үйлчлүүлэгчдийн дундаж тоо</i>	<i>4</i>	<i>3.9</i>	<i>5</i>	<i>7</i>
Бүгд	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	720	686	394	1358
Биеэ үнэлсэн сүүлийн өдөр бэлгийн хавьталд орсон хүний тоо				
<i>Үйлчлүүлэгчдийн дундаж тоо</i>	<i>2</i>	<i>1.5</i>	<i>2</i>	<i>2</i>
Нийт хариулагчдын тоо	720	708	424	1457
Биеэ үнэлээд олдог орлого, 7 хоногийн дундаж дүн, төгрөгөөр				
50,000 хүртэл	39.7	17.6	11.9	6.7 (5.5-7.9)
50,001-150,000	43.6	40.4	31.7	27 (24.9-29.1)
150,000-с дээш	16.7	42.1	56.5	66.3 (64.0-68.6)
<i>Орлогын дундаж</i>	<i>-</i>	<i>181,200</i>	<i>260,540</i>	<i>324,725</i>
Бүгд	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	159	709	379	1210
Сүүлийн 12 сарын хугацаанд биеэ үнэлсэн нийт сар				
<i>Дундаж, голч, моде</i>	<i>-</i>	<i>8.2; 9; 12</i>	<i>7.4; 7; 12</i>	<i>11; 6; 12</i>
Байнгын бус төлбөр төлдөггүй бэлгийн хавьтагчтай ЭБҮ-ийн %	42.2%	36.10%	49.60%	40.5 (38.1-42.9)
Гадаадад биеэ үнэлж байсан ЭБҮ-ийн %	-	10.80%	8.3	9.3 (7.9-10.7)

Сүүлийн 7 хоногт бэлгийн хавьталд орсон үйлчлүүлэгчдийн дундаж тоо 5 байгаа нь 2014 оныхоос 1.1-ээр олон болсон байна. Мөн сүүлийн долоо хоногт 4-өөс олон үйлчлүүлэгчтэй бэлгийн хавьталд орсон ЭБҮ-ийн эзлэх хувь 48.5% байгаа нь 2014 оныхоос 9.7 пунктээр нэмэгдсэн байна. Мөн биеэ үнэлсэн сүүлийн өдөр бэлгийн хавьталд орсон хүний тоо 2 байсан нь 2014 оны судалгааны дүнгээс 0.5-аар өссөн байна.

Сүүлийн 12 сарын дунджаар 7.4 сард нь биеэ үнэлсэн байв. Энэ нь 2014 оны судалгааны дүнгээс 0.8 сараар бага байна.

ЭБҮ-ийн биеэ үнэлээд олдог орлогын дундаж хэмжээ 7 хоногт 260 мянган төгрөг байгаа нь 2014 оныхоос 79 мянгаар нэмэгджээ. 7 хоногт 150 мянган төгрөгөөс их орлоготой ЭБҮ-ийн эзлэх хувь 2014 онд 42.1% байсан бол 2017 онд 56.5% болж

нэмэгдсэн. Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн 49.6% нь байнгын бус төлбөр төлдөггүй бэлгийн хавьтагчтай гэж хариулсан нь 2014 оныхоос 13.5 пунктээр нэмэгдсэн байна. Гадаадад биеэ үнэлж байсан ЭБҮ-ийн хувь 8.3% байгаа нь өмнөх тандалт судалгааны дүнгээс 2.5 пунктээр буурсан байна.

Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн бэлгийн зан үйлийн мэдээллийг дээр Хүснэгт 3.8д дэлгэрэнгүй үзүүлэв.

Биеэ үнэлдэг шалтгаанаа амьжиргаагаа залгуулах мөнгө олох зорилготой гэж хамгийн олон (76%) ЭБҮ хариулсан. Түүнчлэн сарын тогтмол орлого дээр нэмэлт орлого олох зорилготой гэж 12.4% нь хариулсан байна. Мөнгө олох зорилгоор биеэ үнэлдэг ЭБҮ-ийн хувь 2014 онд 93.2% байсан бол 2017 онд 88.4% болж буурсан байна (Зураг 3.6).



Зураг 3.6 Биеэ үнэлж буй гол шалтгаан, ЭБҮ-ийн хувийн жингээр, 2017 он

ЭБҮ нарын 40.0% нь найз нөхдийн сүлжээгээр үйлчлүүлэгчээ олдог гэж хариулсан нь хамгийн их хувийг эзэлж байна. Мөн утсаар холбогдож (34.9%), бар, караоке (25.3%), массажны газар (26.9%), зуучлагчаар дамжуулан (17.9%), саун (16.6%)-нд үйлчлүүлэгчээ олох нь түгээмэл байна.

Хүснэгт 3.9 ЭБҮ-ийн үйлчлүүлэгчээ олдог болон биеэ үнэлж буй газар, хувийн жин, 2017 он

Үйлчлүүлэгч олдог газар	Хувь	Биеэ үнэлдэг газар	Хувь
Бар, караоке	25.3	Бар, караоке	8.1
Зочид буудал	16.2	Зочид буудал	38.4
Дэн буудал	14.0	Дэн буудал	39.5
Утсаар	34.9	Саун	14.6
Саун	16.6	Массажны газар	28.8
Массажны газар	26.9	Үйлчлүүлэгч олж өгдөг зуучлагч	0.4
Интернетийн олон нийтийн сүлжээгээр	5.2		
Найз нөхдийн сүлжээгээр	40.0	Үйлчлүүлэгчийн гэрт	9.0
Үйлчлүүлэгч олж өгдөг зуучлагч	17.9	Хариулахгүй	1.7
Олон нийтийн арга хэмжээнээс	4.4	Бусад	0.0

Хариулахгүй	9.2		
Бусад	8.3		
Нийт хариулагчдын тоо	458	Нийт хариулагчдын тоо	458

Хамгийн түгээмэл биеэ үнэлдэг газар нь зочид буудал (38.4%), дэн буудал (39.5%), массажны газар (28.8%), саун (14.6%) болохыг судалгаагаар тодорхойлов (Хүснэгт 3.9).

ЭБҮ-ийн бэлгэвчийн хэрэглээ

Хамгийн сүүлд бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн хувь 84.3 байгаа нь өмнөх судалгааны дүнгээс 1 пунктээр нэмэгдсэн байна. Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн хувь 51.3 байгаа нь 2014 оны судалгааны дүнгээс 5.6 пунктээр буурсан байна. Сүүлийн 12 сард тохиолдлын бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн хувь 31.7% болж 2014 оныхоос 6.7 пунктээр нэмэгдсэн. Харин байнгын бэлгийн хавьтагчтайгаа бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэдэг ЭБҮ-ийн хувь 15.6 болж өмнөх судалгааны дүнгээс 1.6 пунктээр буурсан байна (Хүснэгт 3.9).

Хүснэгт 3.10 ЭБҮ-ийн бэлгэвчийн хэрэглээ

Үзүүлэлтүүд	Тандалт судалгаа					
	2007	2009	2011	2014	2017	
					Дундаж	Жинлэсэн (95% ИХ)
Сүүлийн удаа бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн						
Хамгийн сүүлд төлбөртэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн %	93.4	90.3	81.2	83.3	84.3	85.1 (83.4-86.8)
Сүүлийн 12 сарын хугацаанд тогтмол бэлгэвч хэрэглэсэн						
Төлбөртэй бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн %	-	61.1	49.1	56.9	51.3	58.8 (56.4-61.2)
Сүүлийн 12 сарын хугацаанд төлбөргүй тохиолдлын бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн %	20.7	33.5	25.4	25.0	31.7	28.0 (25.8-30.2)
Сүүлийн 12 сарын хугацаанд байнгын бэлгийн хавьтагчтайгаа бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн %	4.4	20.8	6.8	17.2	15.6	10.7 (9.2-12.2)

Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн бэлгэвчийн хэрэглээний түвшин судалгааны байршлуудад харилцан адилгүй байна. Хамгийн сүүлд төлбөртэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн эзлэх хувь Дархан-Уул аймагт 97.1 буюу хамгийн өндөр байлаа. Харин энэ үзүүлэлт Хөвсгөл аймагт 68.4 хувь байсан нь хамгийн бага хувь юм.

Сүүлийн 12 сарын хугацаанд төлбөртэй бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн эзлэх хувь Дорнод аймагт 69.4, УБ хотод 63.7 байсан нь судалгааны бусад байршлуудаас илүү үзүүлэлтэй байна. Энэ үзүүлэлт Дархан-Уул аймагт 25.7 хувь, Хөвсгөл аймагт 32.9 хувь, Орхон аймагт 46.4 хувь байлаа.

Хүснэгт 3.11 ЭБҮ-ийн бэлгэвчийн хэрэглээ /байршлаар/

Үзүүлэлтүүд	Судалгаан байршил					
	Дархан-Уул	Дорнод	Хөвсгөл	Орхон	УБ	Дундаж
Сүүлийн удаа бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн						
Хамгийн сүүлд төлбөртэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн %	97.1	85.7	68.4	82.14	85.9	84.3
Сүүлийн 12 сарын хугацаанд тогтмол бэлгэвч хэрэглэсэн						
Төлбөртэй бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн %	25.7	69.4	32.9	46.4	63.7	51.3
Сүүлийн 12 сарын хугацаанд байнгын хавьтагчтайгаа бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн %	20.0	51.0	11.8	10.7	8.7	15.6

ЭБҮ-ээс бэлгэвчгүйгээр бэлгийн хавьталд орж байсан шалтгааныг нь судлахад хамгийн олон буюу 66.7% нь бэлгэвч хэрэглэх дургүй гэж хариулсан. Түүнчлэн 33.3% нь бэлгийн хавьтагч дургүйцдэг, 26.7% нь бэлгэвч худалдаж авахад эвгүй, ичдэг, 20.0% нь бэлгийн хавьтагчдаа итгэдэг, 13.3% нь би согтуу байсан учраас бэлгэвч хэрэглээгүй гэж хариулсан нь хамгийн түгээмэл шалтгаан болж байна (Хүснэгт 3.10).

Хүснэгт 3.12 ЭБҮ-ийн бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан шалтгаан, хувиар, 2017 он

Бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан шалтгаан	Хувь
Бэлгэвч хэрэглэх дургүй	66.7
Тухайн үед бэлгэвч олдоогүй	6.7
Бэлгэвч худалдаж авахад эвгүй, ичдэг	26.7
Би бэлгэвчинд итгэдэггүй	6.7
Бэлгийн хавьтагч дургүйцдэг	33.3
Бэлгийн хавьтагчдаа би итгэдэг	20.0
Би согтуу байсан	13.3
Бэлгэвчгүй үйлчилгээ илүү төлбөр төлдөг	6.7
Жирэмслэлтээс сэргийлэх өөр арга хэрэглэдэг	6.7
Намайг өвчтэй гэж бодно	6.7
Нийт хариулагчдын тоо	15

ЭБҮ-д БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн болон эмчилгээ хийлгэсэн байдал

ЭБҮ-ийн 41.9% нь сүүлийн 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн гэж хариулсан нь 2014 оны судалгааны дүнгээс 12 пунктээр их байна. Мөн ЭБҮ-ийн

57.8% нь БЗДХ-ын шинж тэмдэг илэрсний улмаас эмнэлэгт хандсан гэж хариулсан (Хүснэгт 3.11).

Хүснэгт 3.13 БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн болон эмчилгээ хийлгэсэн байдал, ТС-ны оноор

Үзүүлэлтүүд	Тандалт судалгаа						2017	
	2005	2007	2009	2011	2014	Дундаж	Жинлэсэн (95% ИХ)	
Сүүлийн 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн %	37.1	27.8	38.5	-	29.9	41.9	37.5 (35.2-39.8)	
БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн бөгөөд улсын болон хувийн эмнэлэгт эмчлүүлсэн %	41.6	68.3	86.9	50	88.1	57.8	47.9 (45.5-50.3)	

В. ЭБЭ-ийн бэлгийн зан үйл

Судалгаанд хамрагдсан ЭБЭ-ийн бэлгийн хавьталд анх орсон дундаж нас 17.6, эрэгтэй хүнтэй шулуун гэдсээр бэлгийн хавьталд анх орсон дундаж нас 19 байна. Бэлгийн хавьталд анх орсон насны үзүүлэлт 2014 оны тандалт судалгааны дүнтэй ижил, эрэгтэй хүнтэй анх бэлгийн хавьталд орсон нас 2.7 жилээр залуужсан байна.

ЭБЭ-ийн 49.9% нь анх бэлгийн хавьталд орсон хүнээ эрэгтэй байсан гэж хариулсан бөгөөд эмэгтэй хүнтэй анх бэлгийн хавьталд орсон ЭБЭ-ийн эзлэх хувь 2014 оны судалгааны дүнгээс 9 пунктээр буурсан байна.

Судалгаанд оролцогчдын 63.2% нь гей буюу зөвхөн эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орох бэлгийн чиг баримжаатай байгаа нь 2014 оны тандалт судалгааны дүнгээс 13.8 пунктээр нэмэгдсэн байна. Бисекс бэлгийн чиг баримжаатай ЭБЭ-ийн хувь 2014 оныхоос 16.8 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Харин судалгаанд оролцогчдын 0.4% нь трансжендер буюу өөрийгөө эмэгтэй хүн гэж хүйсээ илэрхийлж байна.

Судалгаанд оролцогчдын дунд анх бэлгийн хавьталд орохдоо би өөрөө хүсч байсан гэж хариулсан хувь 89.7 болж 2014 оны дүнгээс 2.8 пунктээр буурсан бол согтуу байх үедээ анх бэлгийн хавьталд орсон хувь 5.4 болж өмнөх судалгааны дүнгээс 5 пунктээр нэмэгдсэн байна (Хүснэгт 3.14).

Хүснэгт 3.14 ЭБЭ-ийн бэлгийн зан үйл, хувийн жингээр, ТС-ны оноор

Үзүүлэлтүүд	Тандалт судалгаа		
	2014 он		2017 он
	Ерөнхий	Ерөнхий	Жинлэсэн
Анх бэлгийн хавьталд орсон нас			
Анх бэлгийн хавьталд орсон насны дундаж	17.7	17.6	17.6
Анх эрэгтэй хүнтэй шулуун гэдсээр бэлгийн хавьталд орсон насны дундаж	21.7	19	19.5
Бэлгийн чиг баримжаа			
Гей (зөвхөн эрэгтэй хүнд)	49.4	63.2	63.2 (60.7-65.7)

Бисекс (эрэгтэй, эмэгтэй хүнд)	47.1	30.3	30.3 (27.9-32.7)
Гетеросекс (эмэгтэй хүнд)		0.4	0.4 (0.08-0.7)
Хүйсийн илэрхийлэл			
Трансжендер (би эмэгтэй хүн)	2.7	2.3	2.3 (1.5-3.1)
Хариулахгүй		0.4	0.4 (0.08-0.7)
Мэдэхгүй	0.8	3.4	3.4 (2.5-4.3)
Анх бэлгийн хавьталд орсон хүний хүйс			
Эрэгтэй	40.8	49.4	49.4 (46.8-52.0)
Эмэгтэй	59.2	50.2	50.2 (47.6-52.7)
Анх бэлгийн хавьталд орсон шийдвэр			
Өөрөө хүсч байсан	92.5	89.7	89.7 (88.1-91.3)
Бусдын шахалт, дарамт, хүчинд автсан	5.1	3.1	3.1 (2.2-4.0)
Согтуу байсан	0.4	5.4	5.4 (4.2-6.6)
Хариулахгүй	2	1.9	1.9 (1.2-2.6)
Бэлгийн хавьталд голчлон ордог хэлбэр			
Актив	31.1	35.2	35.2 (32.8-37.6)
Пассив	22.8	20.7	20.7 (18.6-22.8)
Универсаль	42.5	40.2	40.2 (37.7-42.7)
Хариулахгүй	3.5	3.8	3.8 (2.8-4.8)
Бүгд	100	100	100
Нийт хариулагчдын тоо	261	261	1464

ЭБЭ-ийн дунд гадаадын иргэдтэй бэлгийн хавьталд орж байсан хүний эзлэх хувь 2014 онд 35.3 байсан бол 2017 онд 41 болж нэмэгдсэн. Сүүлийн 12 сарын хугацаанд 44.4% нь эрэгтэй, 43.3% эмэгтэй хүнтэй тохиолдлын бэлгийн хавьталд орсон байна (Хүснэгт 3.15).

Хүснэгт 3.15 ЭБЭ-ийн бэлгийн эрсдэлт зан үйл, хувиар, 2014, 2017 он

Үзүүлэлтүүд	Тандалт судалгаа хийгдсэн он		
	2014	2017	
		Ерөнхий	Жинлэсэн
Гадаадын иргэнтэй бэлгийн хавьталд орсон ЭБЭ-ийн эзлэх %	35.3	41.0	41.0 (38.5-43.5)
Сүүлийн 12 сард эрэгтэй хүнтэй тохиолдлын бэлгийн хавьталд орж байсан %	54.1	44.4	44.4 (41.9-46.9)
Сүүлийн 12 сард эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орохдоо төлбөр авч байсан %	9.4	4.2	0.4 (0.1-0.7)
Сүүлийн 12 сарын хугацаанд эмэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орсон %	31.4	29.1	29.1 (26.8-31.4)
Сүүлийн 12 сарын хугацаанд эмэгтэй хүнтэй тохиолдлын бэлгийн хавьталд орсон %	46.3	43.4	43.4 (40.9-45.9)
Сүүлийн 12 сарын хугацаанд эмэгтэй биеэ үнэлэгчтэй бэлгийн хавьталд орсон %	4.0	1.3	1.4 (0.8-2.0)

Судалгаанд оролцогчдын 30% (n=79) нь бисекс бэлгийн чиг баримжаатай гэж хариулсан бөгөөд 29% (76) нь сүүлийн 12 сарын хугацаанд эмэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орсон байна. Эмэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд орсон ЭБЭ-ийн

42.1% нь 2 ба түүнээс олон, 57.9% нь 1 эмэгтэйтэй бэлгийн хавьталд орсон гэж хариулав.

Судалгаанд оролцогчдын 94% нь сүүлийн 12 сард эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орсон. Тэдний 52.4% нь 2-4, 19.5% нь 5-аас олон эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орсон гэж хариулав. Сүүлийн 12 сард ЭБЭ-ийн бэлгийн хавьталд орсон эрэгтэй хүний дундаж тоо 4 байна.

ЭБЭ-ийн 4.5% нь сүүлийн 12 сард төлбөртэй бэлгийн хавьталд орж байсан бөгөөд дунджаар 3.1 хүнтэй бэлгийн хавьталд орсон гэж хариулав (Хүснэгт 3.16).

Хүснэгт 3.16 Бэлгийн хавьталд оролцогчдын тоо, ЭБЭ бүлгээр, ТС-ны оноор

Үзүүлэлт	Тандалт судалгаа				2017 жинлэсэн %
	2014		2017		
	Хувь	Тоо	Хувь	Тоо	
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон эмэгтэй хүний тоо					
1	62.5	50	57.9%	44	57.9 (53.2-62.6)
2 ба түүнээс дээш	37.6	30	42.1%	32	42.1 (37.4-46.8)
<i>Дундаж/ голч</i>	<i>2.1 / 1.0</i>		<i>2.6/1.0</i>		<i>2.6/1.0</i>
Бүгд	71	100	100	76	
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон эрэгтэй хүний тоо					
1	32.7	82	28.0	69	28.0 (25.6-30.4)
2-4	49.0	123	52.4	129	52.4 (49.8-55.0)
5 ба түүнээс дээш	18.3	46	19.5	48	19.5 (17.4-21.6)
<i>Дундаж/ голч</i>	<i>3.4/2.0</i>		<i>4.0/2.0</i>		<i>4.0/2.0</i>
Бүгд	100	251	100	246	1380
Сүүлийн 12 сард төлбөртэй бэлгийн хавьталд орсон эрэгтэй хүний тоо					
1-3	-	8	72.7	8	72.8 (61.7-83.9)
4 ба түүнээс дээш	-	5	27.3	3	27.2 (16.1-38.3)
<i>Дундаж/ голч</i>	<i>5.6 / 3.0</i>		<i>3.1/2.0</i>		<i>3.1/2.0</i>
Бүгд		13	100	11	62

ЭБЭ-ийн бэлгэвчийн хэрэглээ

ЭБЭ-ийн 46% нь анх бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн гэж хариулсан нь 2014 оны судалгааны дүнтэй харьцуулахад 12.5 пунктээр нэмэгдсэн байна.

Сүүлийн удаа эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн ЭБЭ-ийн хувь 78.5, эмэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн хувь 63.6 байгаа нь өмнөх судалгааны дүнгээс 1.4-1.9 пунктээр илүү байна.

Бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэдэг ЭБЭ-ийн эзлэх хувь 55.9 байгаа нь 2014 оны судалгааны дүнгээс 11 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт болж байна. Мөн эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэдэг ЭБЭ-ийн хувь 2014 оныхоос 15.3 пунктээр нэмэгдсэн байна (Хүснэгт 3.17).

Хүснэгт 3.17 ЭБЭ-ийн бэлгэвчийн хэрэглээний түвшин

Үзүүлэлт	Хариулт		
	Хувь	Тоо	Жинлэсэн %
Анх бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн	46.0	120	46.0 (43.4-48.6)
Сүүлийн удаа бэлгэвч хэрэглэсэн			
Сүүлийн удаа эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн %	78.5	205	78.5 (76.4-80.6)
Хамгийн сүүлд төлбөр авч бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн %	95.8	250	95.8 (94.8-96.8)
Сүүлийн удаа эмэгтэй хүнтэй тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн %	63.6	21	63.6 (61.1-66.1)
Сүүлийн удаа эмэгтэй биеэ үнэлэгчтэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн %	100	1	100
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгэвч хэрэглэсэн			
Бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэсэн %	55.9	146	55.9 (53.4-58.4)
Сүүлийн 12 сарын хугацаанд эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэсэн %	60.2	157	60.2 (55.7-62.7)
Сүүлийн 12 сарын хугацаанд төлбөр авч бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэсэн %	1.5	4	1.5 (0.9-2.1)

Бэлгэвч хэрэглэхээ мартсан (57.9%), тухайн үед бэлгэвч олдоогүй (23.7%) гэсэн шалтгааны улмаас хамгийн их бэлгэвчгүй бэлгийн хавьталд орсон байна. Түүнчлэн бэлгэвч авах цаг гараагүй, бэлгэвч үнэтэй, бэлгэвч худалдаж авахаас ичдэг, ХДХВ-ийн халдвар болон БЗДХ-аас хамгаалах өөр арга мэддэг гэсэн шалтгааны улмаас бэлгэвч хэрэглээгүй гэж ЭБЭ хариулсан (Хүснэгт 3.18).

Хүснэгт 3.18 ЭБЭ-ийн бэлгэвчгүй бэлгийн хавьталд орсон шалтгаан

Бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан шалтгаан	Хувь
Бэлгэвч хэрэглэхээ мартсан	57.9%
Тухайн үед бэлгэвч олдоогүй	23.7%
Бэлгэвч авах цаг гараагүй	9.2%
Бэлгэвч үнэтэй	3.9%
Бэлгэвч авах эвгүй, ичдэг	2.6%
ХДХВ-ийн халдвар БЗДХ-аас хамгаалах өөр арга хэрэглэдэг	3.9%
Нийт хариулагчдын тоо	76

ЭБЭ-д БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн болон эмчилгээ хийлгэсэн байдал

Судалгаанд оролцсон ЭБЭ-ийн 8.4% нь сүүлийн 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн гэж хариулсан бөгөөд тэдний 54.5% нь улсын болон хувийн эмнэлэгт хандаж эмчилгээ хийлгэсэн гэж хариулсан байна (Хүснэгт 3.19).

Хүснэгт 3.19 БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн болон эмчилгээ хийлгэсэн байдал, ЭБЭ-ийн хувиар, ТС-ны оноор

Үзүүлэлтүүд	2014	2014 Жигнэсэн %	2017 (n=261)	2017 Жигнэсэн %
Сүүлийн 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн %	9.8	7.6	8.4%	8.4% (7.0-9.8)
БЗДХ-ын шинж тэмдэг илэрсний улмаас улсын болон хувийн эмнэлэгт эмчлүүлсэн	84.5	-	54.5%	27.6% (16.5-38.7)

3.1.5 Эрсдэлт бүлгийнхний дундах согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ

Хүснэгтээс харахад ЭБҮ-ийн 50.3% нь долоо хоногт нэгээс олон удаа согтууруулах ундаа хэрэглэж байгаа нь 2014 оны судалгааны дүнгээс 10.4 пунктээр нэмэгдсэн байна. Огт согтууруулах ундаа хэрэглэдэггүй ЭБҮ-ийн эзлэх хувь 2014 онд 16.6% байсан бол 2017 онд 6.7% болж буурсан байна.

Хүснэгт 3.20 Согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ, эрсдэлт бүлгээр

Хорт зуршлын хэрэглээ	ХДХВ-ийн халдварт өртөх эрсдэлтэй бүлэг			
	ЭБҮ		ЭБЭ	
	Хувь	Тоо	Хувь	Тоо
Архи согтууруулах ундааны хэрэглээ				
Өдөр тутам	3.1	14	0.8	2
7 хоногт нэг удаа	14.6	66	15.2	39
7 хоногт нэгээс дээш	32.6	147	13.6	35
Сард нэг удаа	16.9	76	33.9	87
Сард нэгээс дээш	20.4	92	19.8	51
Жилдээ 1-2 удаа	5.8	26	8.9	23
Огт хэрэглэдэггүй	6.7	30	7.8	20
Бүгд	100	451	100	257
Бэлгийн хавьталд орохын өмнөх архи согтууруулах ундааны хэрэглээ				
Байнга	7.1	30	2.1	5
Ихэнхдээ	15.4	65	5.5	13
Заримдаа	36.6	154	22.4	53
Хааяа	20.9	88	35.9	85
Огт хэрэглэдэггүй	19.7	83	34.2	81
Хариулахгүй	0.2	1	0.0	0
Бүгд	100	421	100	237
Мансууруулах бодис хэрэглэж үзсэн эсэх				
Хэрэглэж үзсэн	3.8	17	16.3	42
Хэрэглэж үзээгүй	96.2	430	83.7	215
Бүгд	100	447	100	257

ЭБЭ-ийн 29.6% нь долоо хоногт нэг ба түүнээс олон удаа согтууруулах ундаа хэрэглэдэг гэж хариулсан нь өмнөх тандалт судалгааны дүнгээс 2.1 пунктээр нэмэгдсэн байна. Согтууруулах ундаа огт хэрэглэдэггүй ЭБЭ-ийн хувь 7.8% байгаа нь 2014 оныхтой ойролцоо байна.

Бэлгийн хавьталд орохоос өмнө согтууруулах ундаа хэрэглэх байдлыг нь судлахад ЭБҮ-ийн 22.5%, ЭБЭ-ийн 7.6% нь ихэнхдээ болон байнга хэрэглэдэг гэж хариуллаа. Түүнчлэн ЭБҮ-ийн 36.6%, ЭБЭ-ийн 22.4% нь заримдаа согтууруулах ундаа хэрэглэдэг гэж хариулав. Бэлгийн хавьталд орохоос өмнө согтууруулах ундаа огт хэрэглэдэггүй гэж хариулсан хувь ЭБҮ-ийн дунд 19.7%, ЭБЭ-ийн дунд 34.2% байлаа.

Судалгаанд оролцогчдын дундах мансууруулах бодисын хэрэглээг судлахад ЭБЭ-ийн 16.3%, ЭБҮ-ийн 3.8% нь ямар нэг мансууруулах бодис хэрэглэсэн гэж хариулав. Мансууруулах бодисын хэрэглээ 2014 оноос хойш ЭБЭ нарын дунд 7.3 пункт, ЭБҮ нарын дунд 1.2 пунктээр нэмэгдсэн байна. Эрсдэлт бүлгийн хүн амын дундах согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээний талаарх үр дүнг Хүснэгт 3.18-д дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 3.21 Мансууруулах бодисын төрөл болон хэрэглэх хэлбэр, эрсдэлт бүлгээр

Мансууруулах бодис хэрэглэсэн байдал	ХДХВ-ийн халдварт өртөх эрсдэлтэй бүлэг	
	ЭБҮ	ЭБЭ
Хэрэглэж үзсэн мансууруулах бодисын төрөл		
Өвс, цавуу	10	23
Какойн	-	1
Марихуан	-	5
Газ	-	3
Бонго	-	1
Фофорс	-	1
Эм	1	1
Морфин	-	1
Тамхи	-	6
Шингэн хар тамхи	2	-
Нунтаг цагаан	1	-
Мансууруулах бодис хэрэглэсэн арга, хэлбэр		
Үнэртэх, сорох	11	13
Зажлах	1	0
Татах	5	26
Уух	-	2
Булчин тариа	-	0
Судас тариа	-	1
Бусад	-	0
Бүгд	17	42

Мансууруулах бодис хэрэглэдэг ЭБҮ, ЭБЭ нарын дунд өвс, цавууг хамгийн түгээмэл хэрэглэж байна. Түүнчлэн марихуан, хий, тамхи, бонго, фосфор, какойн зэргийг мансуурах зорилгоор хэрэглэж байна. ЭБҮ нар үнэртэх, сорох, зажлах, татах хэлбэрээр мансууруулах бодисыг хэрэглэж байхад, ЭБЭ нар үнэртэх, сорох, татахаас гадна уух, судсанд тарих хэлбэрээр хэрэглэж байна (Хүснэгт 3.19).

3.1.6 ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүртээмж, үр нөлөө

Судалгаанд оролцсон ЭБҮ-ийн 84.5% (n=387), ЭБЭ-ийн 94.4% (n=235) нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэж байсан гэж хариулав. Харин сүүлийн 12 сард шинжилгээ хийлгэсэн ЭБҮ-ийн эзлэх хувь 80.9, ЭБЭ нарт 89.8 байлаа. ХДХВ--

ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан ЭБЭ болон ЭБҮ-ийн эзлэх хувь 2014 оныхоос нэмэгдсэн байна.

ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан ЭБҮ-ийн 71.8%, ЭБЭ-ийн 72.5% нь сайн дураараа шинжилгээг хийлгэх шийдвэр гаргасан байна. Сайн дураараа шинжилгээ өгөх шийдвэр гаргасан хүмүүсийн эзлэх хувь 2014 оноос хойш ЭБҮ бүлэгт 5.8 пункт, ЭБЭ бүлэгт 10.7 пунктээр буурсан байна.

Судалгаанд хамрагдсан ЭБЭ-ийн ихэнх буюу 72.5% нь Гранд плаза дахь ЭБЭ олон нийтийн төвд шинжилгээнд хамрагдсан байна. 20.3% нь ХӨСҮТ, үлдсэн хувь нь дүүргийн эрүүл мэндийн төв, хувийн эмнэлгүүдэд шинжилгээ хийлгэсэн гэж хариулав. Сүүлийн 12 сард шинжилгээ хийлгэсэн ЭБҮ (n=387)-ийн 90.4%, ЭБЭ (n=207)-ийн 98.1% нь хариугаа авсан буюу халдвартай эсэхээ мэдэж байсан гэж хариулав. Тандалт судалгаагаар ЭБЭ-ийн дунд 24 хүн ХДХВ-ийн халдвартай нь тогтоогдсон бөгөөд тэд бүгдээрээ халдвартай эсэхээ мэдэж байсан байна (Хүснэгт 3.22).

Хүснэгт 3.22 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ, үйлчилгээнд хамрагдсан байдал, эрсдэлт бүлгээр, 2017 он

Сонгосон үзүүлэлт	ЭБҮ		ЭБҮ Жинлэсэн % (95% ИХ)	ЭБЭ		ЭБЭ Жинлэсэн % (95% ИХ)
	Хувь	Тоо		Хувь	Тоо	
ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэж байсан						
Шинжилгээ хийлгэж байсан	84.5	387.0	86.5 (84.9-88.1)	94.4	235	94.3 (93.1-95.5)
Шинжилгээ хийлгэж байгаагүй	15.5	71.0	13.5 (11.9-15.1)	5.6	14	5.7 (4.5-6.90)
Бүгд	100.0	458.0	100.0	100.0	249	1397
Сүүлийн 12 сард ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн						
Шинжилгээ хийлгэсэн	80.9	313.0	80.6 (78.5-82.7)	89.8	211	89.8 (88.2-91.4)
Шинжилгээ хийлгээгүй	19.1	74.0	19.4 (17.3-21.5)	10.2	24	10.2 (8.6-11.8)
Бүгд	100.0	387.0	100.0	100.0	235	1318
Шинжилгээ хийлгэх шийдвэр гаргалт						
Сайн дураараа	71.8	278.0	73.7 (71.3-76.1)	72.5	153	72.6 (70.1-75.1)
Шаардлага гарсны улмаас	14.0	54.0	17.1 (15.1-19.1)	23.2	49	23.3 (20.9-25.7)
Үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар	14.2	55.0	9.1 (7.6-10.6)	4.3	9	4.2 (3.1-5.3)
Бүгд	100.0	387.0	100.0	100.0	211	
Сүүлийн 12 сард ХДХВ-ийн халдвар ирүүлэх шинжилгээ хийлгэсэн газар						
ХӨСҮТ	Na	Na	Na	20.3	43	20.4 (18.1-22.7)
Дүүрэг/аймаг/ сумын эмнэлэг	Na	Na	Na	3.3	7	3.3 (2.3-4.3)
Хувийн эмнэлэг/ лаборатори	Na	Na	Na	1.9	4	1.9 (1.1-2.7)
Гранд плаза дахь ЭБЭ олон нийтийн төв	Na	Na	Na	72.5	153	72.6 (70.1-75.1)


Бусад	Na	Na	Na	1.9	4	1.9 (1.1-2.7)
Бүгд	Na	Na	Na	1.0	211	1182
Шинжилгээний хариугаа авсан эсэх						
Хариугаа авсан	90.4	350.0	89.6 (88.0-91.2)	98.1	207	98.1 (97.3-98.9)
Хариугаа аваагүй	9.6	37.0	10.4 (8.8-12.0)	1.9	4	1.9 (1.1-2.7)
Бүгд	100.0	387.0	100.0	100.0	211	1182
Шинжилгээний хариуг эерэг байна гэж хэлж байсан эсэх						
Тийм	7.5	29.0	7.3 (5.9-8.7)	11.5	24	12.6 (10.7-14.5)
Үгүй	92.5	358.0	92.7 (91.3-94.1)	87.9	182	86.9 (85.0-88.8)
Хариулахгүй	0.0	0.0	0.0	0.5	1	0.5 (0.1-0.9)
Бүгд	100.0	387.0	100.0	100.0	207	1162

Судалгаанд оролцсон нийт ЭБҮ-ийн 76.4%, ЭБЭ-ийн 79.3% нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн бөгөөд халдартай эсэхээ мэдэж байгаа гэж хариулсан. Харин сүүлийн 12 сард ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан ЭБҮ 55.2%, ЭБЭ 51.0% эзэлж байлаа (Хүснэгт 3.23). ЭБЭ нарын дундах урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүртээмжийн хувийг Улаанбаатар болон бусад аймгаар тооцохдоо тэдний засаг захиргааны үндсэн харьяалалд үндэслэв.

Хүснэгт 3.23 ЭБҮ-ийн ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх үйлчилгээний хүртээмж


Үйлчилгээнд хамрагдсан байдал	ЭБҮ	ЭБЭ
ХДХВ-ийн халдвартай эсэхээ мэдэж байгаа хүний эзлэх %	76.4	79.3
Улаанбаатар	75.9	79.3
Дархан-Уул	88.4	71.4
Орхон	56.7	87.5
Дорнод	88.7	100.0
Хөвсгөл	73.8	80.0
Сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдаж байсан %	55.2	51.0
Улаанбаатар	44.7	52.1
Дархан-Уул	75.4	42.9
Орхон	36.6	62.5
Дорнод	71.6	66.7
Хөвсгөл	53.8	40.0

ХДХВ-ийн халдвартай эсэхээ мэдэж байгаа ЭБҮ болон ЭБЭ-ийн эзлэх хувь 2011 оноос хойш нэмэгдсэн хандлага харагдаж байна (Зураг 3.7).



Зураг 3.7 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэж, хариугаа авсан хүн амын эзлэх хувь, эрсдэлт бүлгээр, ТС-ны оноор

Судалгаанд хамрагдсан эрсдэлт бүлгийнхэн ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдах байдал 2014 оныхоос 3.2-9.1 пунктээр нэмэгдсэн байна. 2017 оны судалгаагаар урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдалт ЭБЭ-ийн дунд 51%, ЭБҮ-ийн дунд 55.2%-тай байна (Зураг 3.8).




Зураг 3.8 Сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан хувь, эрсдэлт бүлгээр, ТС-ны оноор

ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанаас ЭБҮ-д зориулсан сайн дурын зөвлөгөө, шинжилгээ (67.6%), бэлгэвч, чийгшүүлэгч тараах (66%), сургалт (39.9%) хамгийн их хамрагдалттай байна. ЭБЭ-ийн тухайд сургалтын үйл ажиллагаа хамгийн их хамрагдалттай (69.9%) байсан бол бусад үйл ажиллагаанд 3.8-9% нь хамрагдсан байна (Хүснэгт 3.24).

Хүснэгт 3.24 Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэл, эрсдэлт бүлгээр, 2017 он

Сонгосон үзүүлэлтүүд	Эрсдэлт бүлэг					
	ЭБҮ		ЭБҮ Жинлэсэн % (95% ИХ)	ЭБЭ		ЭБЭ Жинлэсэн % (95% ИХ)
	Хувь	Тоо		Хувь	Тоо	
Хамрагдсан үйл ажиллагааны төрөл						
Сургалт	39.9	101	28.0 (25.0-31.0)	69.9	93	70.0 (66.7-73.3)
Бүлгийн ярилцлага	24.5	62	21.9 (19.1-24.7)	6.0	8	6.0 (4.3-7.7)
Сайн дурын зөвлөгөө, шинжилгээ	67.6	171	73.3 (70.3-76.3)	7.5	10	7.5 (5.6-9.4)
Идэвхжүүлэх үйл ажиллагаа	13.0	33	8.3 (6.4-10.2)	9.0	12	9.0 (6.9-11.1)
Бэлгэвч, чийгшүүлэгч хүлээн авсан	66.0	167	60.4 (57.1-63.7)	3.8	5	3.8 (2.4-5.2)
БЗДХ-ын оношлогоо	20.6	52	17.1 (14.6-19.6)	3.8	5	3.8 (2.4-5.2)
Бүгд		253	843	100	133	746
ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх бол очих газраа мэдэх эсэх						
Мэднэ	92.8	425	94.4 (93.3-95.5)	97.6	243	97.6 (96.8-98.4)
Мэдэхгүй	7.2	33	5.6 (4.5-6.7)	2.4	6	2.4 (1.6-3.2)
Бүгд	100	458	1660	100	249	1397

ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах байдал ЭБҮ-ийн дунд судалсан дүнг зураг 3.9-д харууллаа. Сүүлийн удаа төлбөр авч бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн эзлэх хувь 2014 оныхоос өөрчлөгдөөгүй байна. Түүнчлэн сүүлийн 12 сарын хугацаанд төлбөр авч бэлгийн хавьталд орох болгондоо бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн хувь буурсан дүн гарсан. Харин сургалт сурталчилгаа зэрэг урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан ЭБҮ-ийн эзлэх хувь 2014 оныхоос нэмэгдсэн (Зураг 3.9).



Зураг 3.9 ЭБҮ-ийн ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөө, ТС-ны оноор

3.1.7 Хүний эрхийн зарим асуудал

Судалгаанд оролцсон ЭБҮ-ийн дунд халдашгүй байдлыг нь зөрчих, цагдаагийн ажилтан болон бар, буудал, сауны эздийн зүгээс дарамт, сүрдүүлэг ирэх, ажил хөдөлмөр эрхлэхэд нь бэрхшээл тулгарах зэргээр эрх нь зөрчигддөг гэж хариулж байна. ЭБЭ-ийн дунд халдашгүй байдал нь зөрчигдөх байдал хамгийн түгээмэл тохиолдож байна (Хүснэгт 3.25).

Хүснэгт 3.25 Хүний эрх, ялгаварлан гадуурхалттай холбоотой гарч байсан бэрхшээлүүд, ЭБЭ, ЭБҮ-ийн хувиар, 2017 он

Бэлгийн зан үйлээс үүдэн хүний эрх, ялгаварлан гадуурхалттай холбоотой гарч байсан хүндрэл бэрхшээл	ЭБҮ	ЭБЭ
Ажил хөдөлмөр эрхлэх	12.4	6.1
Сурах	1.5	6.1
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах	2.8	2.3
Халдашгүй байх	28.2	19.5
Чөлөөтэй зорчих	2.4	3.1
Цагдаа, хуулийн байгууллага хамгаалахаас татгалзах	-	5.0
Цагдаагийн ажилтны зүгээс бэлгийн дарамт үзүүлэх	6.6	-
Цагдаагийн ажилтны зүгээс дарамт, сүрдүүлэг	17.9	-
Бар, буудал, сауны эздийн зүгээс дарамт, сүрдүүлэг	13.8	-
Бусад	45	1.5
Нийт хариулагчдын тоо	458	261.0

Судалгаанд оролцсон ЭБҮ-ийн 7.1% нь хэн нэгний дарамт шахалтаар биеэ үнэлж байсан гэж хариулав. Өөрөөр хэлбэл ЭБҮ-ийн дунд хүний эрх зөрчигдөх асуудал байна.

Хүснэгт 3.26 Хэн нэгний нөлөөн дор хүчээр биеэ үнэлж байсан, ЭБҮ-ийн хувийн жингээр, 2017 он

Сонгосон үзүүлэлтүүд	Хувь	Хариулагчдын тоо
Хэн нэгний нөлөөн дор хүчээр биеэ үнэлж байсан эсэх		
Тийм	7.1	32
Үгүй	92.9	419
Бүгд	100	451

3.2 ОЮУТАН ЗАЛУУЧУУДЫН СУДАЛГААНЫ ДҮН

3.2.1 Судалгаанд хамрагдсан хүн амын шинж байдал

Судалгаанд хамрагдсан нийт 1874 оюутны хүн ам зүйн шинж байдлыг хүснэгт 3.27-д сонгосон үзүүлэлтүүдээр харуулав. Нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын 46.0 хувь нь эрэгтэй 54.0 хувь нь эмэгтэй байсан ба тэдний дундаж нас 20 байв. Судалгаанд хамрагдсан оюутнуудын 1.8 хувь нь гэрлэсэн, 22.5 хувь нь хамтран амьдрагчтай, 75.7 хувь нь гэрлээгүй залуучууд байв.

Хүснэгт 3.27 Хүн ам зүйн шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд, хүйсээр

Хүн ам зүйн шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд	Нийт	Жинлэсэн % (95% ИХ)	Эрэгтэй	Эмэгтэй
Хүйс				
Эрэгтэй	46.0	41.8 (41.6-42.0)	-	-
Эмэгтэй	54.0	58.2 (58.0-58.4)	-	-
Насны бүлэг				
18-аас доош	16.1	16.0 (15.8-16.2)	17.3	15.0
18-22	77.5	77.8 (77.6-78.0)	74.7	79.9
22-оос дээш	6.4	6.3 (6.2-6.4)	8.0	5.0
Насны дундаж/голч нас	20/20	20/20	20.1/20	20/20
Гэрлэлтийн байдал				
Гэрлэсэн	1.8	1.8 (1.7-1.9)	1.7	1.8
Гэрлээгүй	75.7	75.9 (75.7-76.1)	73.2	77.8
Хамтран амьдрагчтай (найз залуу эсвэл охинтой)	22.5	22.3 (22.1-22.5)	25.0	20.3
Бүгд	100	100	100	100
Хариулагчдын тоо	1874	157138	863	1011

Судалгаанд хамрагдсан 15-24 насны оюутан залуучуудын 63.3 хувь нь төрийн өмчийн их дээд сургуульд, 31.1 хувь нь хувийн өмчийн их дээд сургуульд, 5.5 хувь нь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд суралцдаг байна. Суралцаж буй дамжааны хувьд 34.0 хувь нь 1-р дамжаа, 27.2 хувь нь 2-р дамжаа, 14.9 хувь нь 3-р дамжаа, 21.7 хувь нь 4-р дамжаа, 2.2 хувь нь 5 болон 6-р дамжааны оюутнууд байна.

Суралцаж буй мэргэжлийн хувьд инженерчлэл, үйлдвэр, зохион байгуулалт, эрүүл мэндийн чиглэлээр суралцдаг оюутнууд хамгийн их байсан буюу 31.7 хувь нь инженерчлэлийн чиглэлээр, 18.7 хувь нь эрүүл мэндийн чиглэлээр суралцаж байна. Эрэгтэй оюутнуудын хувьд 43.1 хувь нь инженерчлэлийн чиглэлээр, 12.4 хувь нь бизнесийн удирдлага, эрх зүйн чиглэлээр суралцаж байгаа бол эмэгтэй оюутнууд эрүүл мэнд, инженерчлэл, урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр голчлон суралцаж байна.

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 36.5 хувь нь гэртээ, гэр бүлийн хамт амьдардаг бол 36.6 хувь нь оюутны байранд, 14.0 хувь нь хамаатны гэрт, 1.4 хувь нь гэртээ ганцаараа, 11.1 хувь нь түрээсийн орон сууц болон нийтийн байранд амьдардаг байна (Хүснэг 3.28).

Нийт 1874 оюутан залуучууд **тэмбүүгийн халдвар** илрүүлэх шинжилгээнд хамрагдсан бөгөөд тэдний **0.6 хувь нь** буюу 12 оюутан **халдвартай** байлаа.

<u>Хүснэгт 3.28 Нийгэм, эдийн засгийн шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд, хүйсээр</u>				
Нийгэм, эдийн засгийн шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд	Нийт	Жинлэсэн % (95% ИХ)	Эрэгтэй	Эмэгтэй
Суралцдаг сургууль				
Төрийн өмчийн их дээд сургууль	63.3	63.7 (63.5-63.9)	59.4	66.7
Хувийн өмчийн их дээд сургууль	31.1	30.9 (30.7-31.1)	33.5	29.1
Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	5.5	5.4 (5.3-5.5)	7.1	4.3
Суралцаж буй дамжаа				
1	34.0	33.9 (33.7-34.1)	36.0	32.3
2	27.2	27.4 (27.2-27.6)	24.3	29.7
3	14.9	14.9 (14.7-15.1)	15.2	14.6
4	21.7	21.6 (21.4-21.8)	22.2	21.2
5	2.0	2.0 (1.9-2.1)	2.1	2.0
6	0.2	0.2	0.1	0.2
Суралцаж буй мэргэжлийн чиглэл				
Боловсрол	8.0	7.9 (7.8-8.0)	9.0	7.1
Урлаг, хүмүүнлэг, хэл	12.5	13.0 (12.8-13.2)	6.7	17.5
Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	5.0	5.1 (5.0-5.2)	3.4	6.4
Бизнесийн удирдлага, эрх зүй	10.2	10.1 (10.0-10.2)	12.4	8.4
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	5.1	5.1 (5.0-5.2)	4.2	5.8
Мэдээлэл харилцаа холбооны технологи	2.4	2.3 (2.2-2.4)	3.5	1.5
Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт	31.7	30.8 (30.6-31.0)	43.1	22.0
Хөдөө аж ахуй	2.6	2.7 (2.6-2.8)	1.2	3.9
Эрүүл мэнд	18.7	19.2 (19.0-19.4)	11.7	24.6
Нийгмийн хамгаалал	2.5	2.4 (2.3-2.5)	3.2	1.8
Үйлчилгээ	1.3	1.3 (1.2-1.4)	1.6	1.0
Амьдардаг газар				
Гэртээ гэр бүлийн хамт	36.5	36.3 (36.1-36.5)	38.7	34.6
Гэртээ ганцаараа	1.4	1.4 (1.3-1.5)	2.1	0.9
Хамаатны гэрт	14.0	13.9 (13.7-14.1)	15.2	13.1
Түрээсийн орон сууцанд	9.8	9.8 (9.7-9.9)	9.6	9.9
Оюутны байранд	36.6	37.0 (36.8-37.2)	32.6	40.2
Түрээсийн нийтийн байранд	1.3	1.3 (1.2-1.4)	1.4	1.3
Бусад	0.3	0.3	0.5	0.1
Бүгд	100	100.0	100	100
Хариулагчдын тоо	1874	157138.0	863	1011

3.2.2 ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага

ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх хувь буюу зөв мэдлэгийн түвшинг тодорхойлон үр дүнг хүснэгт 3.29-д харуулав.

Хүснэгт 3.29 ХДХВ,ДОХ-ын талаарх мэдлэг, хүйсээр

ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг	Нийт	Жинлэсэн % (95% ИХ)	Эрэгтэй	Эмэгтэй
ХДХВ, ДОХ-ын талаар сонсож байсан	92.6	92.7 (92.6-92.8)	92.7	92.0
Бэлгийн үнэнч нэг хавьтагчтай байснаар ХДХВ-ийн халдвар дамжих эрсдлийг бууруулна	68.1	67.8 (67.6-68.0)	72.1	64.8
Бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвчийг хэрэглэснээр ХДХВ-ийн халдвараас сэргийлж чадна	81.4	81.1 (80.9-81.3)	85.5	77.9
ХДХВ-ийн халдвар дамжихаас сэргийлэх аргуудыг мэддэг хүн амын эзлэх %	63.0	62.7 (62.5-62.9)	68.4	58.6
Гаднаас нь харахад эрүүл хүн ХДХВ-ийн халдвартай байж болно	73.0	73.0 (72.8-73.2)	73.7	72.5
ХДХВ-ийн халдвар шумуулд хазуулахад дамжихгүй	36.2	36.4 (36.2-36.6)	33.0	38.9
ХДХВ-ийн халдвартай хүнтэй гар барих, хоол хүнсээ хувааж идэхэд ХДХВ-ийн халдвар дамжихгүй	71.6	71.6 (71.4-71.8)	72.7	70.8
ХДХВ-ийн халдвар дамжих замын талаар зөв ойлголттой хүн амын эзлэх %	27.3	28.0 (27.8-28.2)	25.6	28.4
ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх %	21.4	-	21.6	21.3

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 92.6 хувь нь ХДХВ, ДОХ-ын талаар сонсож байсан бол 63.0 хувь нь ХДХВ-ийн халдвар дамжихаас сэргийлэх аргуудыг мэддэг, 27.3 хувь нь ХДХВ-ийн халдвар дамжих замын талаар зөв ойлголттой байна. ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх хувь 21.4 байна.

ХДХВ-ийн халдвар дамжихаас сэргийлэх аргуудын талаар болон халдвар дамжих замын талаар зөв ойлголттой хүн амын эзлэх хувь улсын сургуульд суралцдаг оюутнуудын дунд илүү өндөр байна. Харин мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудын дунд халдвар дамжихаас сэргийлэх аргууд болон халдвар дамжих замын талаар мэдлэгтэй оюутнууд харьцангуй бага хувийг эзэлж байна.

Хүснэгт 3.30 ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, суралцдаг сургуулиар

ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг	Улсын сургууль	Хувийн сургууль	МСҮТ
ХДХВ, ДОХ-ын талаарх сонсож байсан	95.9	86.3	92.6
Бэлгийн үнэнч нэг хавьтагчтай байснаар ХДХВ-ийн халдвар дамжих эрсдлийг бууруулна	74.1	60.0	45.2
Бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвчийг хэрэглэснээр ХДХВ-ийн халдвараас сэргийлж чадна	84.2	75.6	82.7
ХДХВ-ийн халдвар дамжихаас сэргийлэх аргуудыг мэддэг хүн амын эзлэх %	68.7	54.9	44.2
Гаднаас нь харахад эрүүл хүн ХДХВ-ийн халдвартай байж болно	75.7	67.4	75.0
ХДХВ-ийн халдвар шумуулд хазуулахад дамжихгүй	37.1	36.2	26.0
ХДХВ-ийн халдвартай хүнтэй гар барих, хоол хүнсээ хувааж идэхэд ХДХВ-ийн халдвар дамжихгүй	74.9	67.9	55.8
ХДХВ-ийн халдвар дамжих замын талаар зөв ойлголттой хүн амын эзлэх %	28.6	25.4	19.2
ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх %	22.8	20.2	11.5

Судалгаанд оролцсон оюутнуудаас ХДХВ-ийн халдвар дамжих хамгийн өндөр эрсдэлтэй бэлгийн хавьтлыг тодорхойлох асуултыг асуусан ба нийт оюутнуудын 55.0 хувь нь үтрээгээр бэлгийн хавьталд орох нь хамгийн өндөр эрсдэлтэй гэж үзсэн бол эрэгтэй оюутнуудын 62.6 хувь нь мөн уг хариултыг сонгосон. Харин эмэгтэй оюутнуудын 44.6 хувь нь энэхүү асуултад мэдэхгүй гэж хариулжээ. Нийт оюутнуудын 35 орчим хавь нь энэхүү асуултад хариулж мэдэхгүй байна.

Хүснэгт 3.31 Халдвар дамжих хамгийн эрсдэлтэй бэлгийн хавьтлын төрөл

	Нийт (n=1875)	Жинлэсэн % (95% ИХ)	Эрэгтэй	Эмэгтэй
Үтрээгээр бэлгийн хавьталд орох	55.0	54.4 (54.2-54.6)	62.6	48.6
Шулуун гэдсээр бэлгийн хавьталд орох	6.7	6.5 (6.4-6.6)	9.8	4.1
Амаар бэлгийн хавьталд орох	2.1	2.1 (2.0-2.2)	2.4	1.8
Мэдэхгүй	35.1	36.0 (35.8-36.2)	23.8	44.6
Бусад	1.1	1.0 (0.95-1.05)	1.4	0.8

3.2.3 Бэлгийн зан үйл, дадал

Судалгаанд хамрагдсан оюутнуудын 61.4 хувь нь бэлгийн хавьталд орж үзсэн бөгөөд эрэгтэй оюутнуудын 78.8 хувь нь, эмэгтэй оюутнуудын 46.5 хувь нь бэлгийн хавьталд орж үзсэн байна. Анх бэлгийн хавьталд орсон нас нь эрэгтэй оюутнуудын хувьд харьцангуй эрт байгаа бөгөөд эрэгтэй оюутнуудын 36.4 хувь нь 16-аас доош насандаа анх бэлгийн хавьталд орсон байна. Харин эмэгтэй оюутнуудын 7.4 хувь нь 16 хүртэл насандаа, 86.6 хувь нь 16-20 хүртэл насандаа, 6.1 хувь нь 20 ба түүнээс дээш насандаа анх бэлгийн хавьталд орж байсан байна. Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон оюутнуудын тоо эрэгтэй оюутнуудын дунд мөн өндөр байна. Эмэгтэй оюутнуудын 91.2 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд 1 хүнтэй бэлгийн хавьталд орсон бол эрэгтэй оюутнуудын 60.6

хувь нь 1 хүнтэй, 35.3 хувь нь 2-4 хүнтэй, 4.1 нь 5-аас дээш хүнтэй бэлгийн хавьталд орсон байна.

Сүүлийн 12 сарын хугацаанд төлбөр авч бэлгийн хавьталд орсон оюутан байхгүй байгаа ба эрэгтэй оюутнуудын 38.0 хувь, эмэгтэй оюутнуудын 22.5 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд орсон байна.

Бэлгийн хавьталд орж үзсэн оюутнуудын нийт оюутнуудад эзлэх хувиар МСҮТ-ийн оюутнууд хамгийн бага байгаа ба 47.1 хувь нь бэлгийн хавьталд орж үзсэн бол улсын болон хувийн өмчийн их дээд сургуульд суралцагсдын ойролцоогоор 62.0 хувь нь бэлгийн хавьталд орж үзсэн байна.

Харин анх бэлгийн хавьталд орсон нас нь МСҮТ-ийн оюутнуудын хувьд илүү залуу байна. Өөрөөр хэлбэл МСҮТ-ийн оюутнуудын 24.5 хувь нь 16 наснаасаа өмнө бэлгийн хавьталд орсон бол хувийн сургуулийн оюутнуудын 11.7 хувь, улсын сургуулийн оюутнуудын 7.8 хувь нь 16 нас хүрээгүй байхдаа анх бэлгийн хавьталд орсон байна.

Улсын сургуулийн оюутнуудын 78.5 хувь, хувийн сургуулийн оюутнуудын 83.0 хувь, МСҮТ-ийн оюутнуудын 73.5 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орж байсан байна. Сүүлийн 12 сарын хугацаанд 5-аас дээш хүнтэй бэлгийн хавьталд орсон оюутнуудын тоо хувийн сургуулийн оюутнуудын дунд хамгийн өндөр буюу 3.8 хувьтай байгаа бол, улсын сургуулийн оюутнуудын хувьд 1.8 хувь, харин 5-аас дээш хүнтэй бэлгийн хавьталд орсон МСҮТ-ийн оюутан байхгүй байна. Улсын сургуульд суралцагсдын 33.6 хувь, хувийн сургуульд суралцагсдын 27.5 хувь, МСҮТ-д суралцагсдын 34.8 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд орсон байна.

Хүснэгт 3.32. Бэлгийн зан үйл дадал, хүйсээр

Үзүүлэлтүүд	Нийт	Жинлэсэн % (95% ИХ)	Эрэгтэй	Эмэгтэй
Бэлгийн хавьталд орж үзсэн эсэх				
Тийм	61.4	60.0 (59.8-60.2)	78.8	46.5
Үгүй	38.6	40.0 (39.8-40.2)	21.2	53.5
Анх бэлгийн хавьталд орсон нас				
16 хүртэл	24.3	23.0 (22.7-23.3)	36.4	7.4
16-20	72.7	73.7 (73.4-74.0)	62.7	86.6
20 ба түүнээс дээш	3.1	3.3 (3.2-3.40)	0.9	6.1
<i>Анх бэлгийн хавьталд орсон насны дундаж</i>	<i>17.5</i>	<i>17.6</i>	<i>17</i>	<i>18.3</i>
Бүгд	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	1108	90939	646	462
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон эсэх				
Тийм	79.7	79.5 (79.2-79.8)	81.2	77.5
Үгүй	19.9	20.1 (19.8-20.4)	18	22.5
Санахгүй байна	0.4	0.4 (0.36-0.44)	0.8	0.0
Бүгд	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	1127	92383	665	462
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон хүний тоо				
1	73	74.3 (74.0-74.6)	60.6	91.2
2-4	24.6	23.4 (23.1-23.7)	35.3	8.8

5-аас дээш	2.4	2.2 (2.1-2.30)	4.1	0
<i>Дундаж</i>	<i>1.5</i>	<i>1.5</i>	<i>1.8</i>	<i>1.1</i>
Бүгд	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	867	71021	515	352
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орохдоо төлбөр авсан эсэх				
Тийм	0	-	-	-
Үгүй	100	-	-	-
Нийт хариулагчдын тоо	890	-	-	-
Сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд орсон эсэх				
Тийм	31.8	31.1 (30.8-31.4)	38.0	22.5
Үгүй	68.2	68.9 (68.6-69.2)	62.0	77.5
Бүгд	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	1099	89994	655	444

Бэлгийн хавьталд орж үзсэн оюутнуудын тоо гэртээ ганцаараа амьдардаг оюутнуудын дунд хамгийн өндөр буюу 81.5 хувь байгаа бол гэртээ, гэр бүлийн хамт амьдардаг оюутнуудын 65.6 хувь, хамаатны гэрт амьдардаг оюутнуудын 57.0 хувь, оюутны байранд амьдардаг оюутнуудын 63.0 хувь нь бэлгийн хавьталд орж үзсэн байна. Мөн гэртээ ганцаараа амьдардаг оюутнууд харьцангуй эрт бэлгийн хавьталд орж үзсэн ба 13.6 хувь нь 16 наснаасаа өмнө бэлгийн хавьталд орсон байна. Харин гэртээ гэр бүлийн хамт амьдардаг оюутнуудын 9.0 хувь, хамаатны гэрт амьдардаг оюутнуудын 10.9 хувь, оюутны байранд амьдардаг оюутнуудын 11.8 хувь, түрээсийн байранд амьдардаг оюутнуудын 5.5 хувь нь 16 наснаасаа өмнө бэлгийн хавьталд орсон байна. Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон оюутнууд нийт оюутнуудын 80 орчим хувийг эзэлж байгаа ба түрээсийн байранд амьдардаг оюутнуудын дунд уг үзүүлэлт хамгийн өндөр буюу 87.6 хувь байна.

Хүснэгт 3.33. Оюутан залуусын бэлгийн зан үйл, суралцдаг сургуулиар

Үзүүлэлтүүд	Улсын сургууль	Хувийн сургууль	МСҮТ
Бэлгийн хавьталд орж үзсэн эсэх			
Тийм	62.6	61.4	47.1
Үгүй	37.4	38.6	52.9
Анх бэлгийн хавьталд орсон нас			
16 хүртэл	7.8	11.7	24.5
16-20	80.1	80.1	71.4
20 ба түүнээс дээш	12	8.3	4.1
<i>Анх бэлгийн хавьталд орсон насны дундаж</i>	<i>17.7</i>	<i>17.3</i>	<i>16.6</i>
Бүгд	100	100	100
Нийт хариулагчдын тоо	708	351	49
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон эсэх			
Тийм	78.5	83	73.5
Үгүй	21.3	16.8	22.4
Санахгүй байна	0.3	0.3	4.1
Бүгд	100	100	100
Нийт хариулагчдын тоо	720	358	49
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон хүний тоо			
1	73.8	72.1	68.6
2-4	24.4	24.1	31.4
5-аас дээш	1.8	3.8	0
<i>Дундаж</i>	<i>1.5</i>	<i>1.6</i>	<i>1.5</i>

Бүгд	100	100	100
Нийт хариулагчдын тоо	542	290	35
Сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд орсон эсэх			
Тийм	33.6	27.5	34.8
Үгүй	66.4	72.5	65.2
Бүгд	100	100	100
Нийт хариулагчдын тоо	711	342	46

Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон хүний тоогоор гэртээ ганцаараа амьдардаг оюутнууд хамгийн өндөр байгаа ба нийт оюутнуудын 20.0 хувь нь 5-аас дээш тооны хүнтэй бэлгийн хавьталд орсон байна.

Гэртээ, гэр бүлийн хамт амьдардаг оюутнуудын 27.5 хувь, гэртээ ганцаараа амьдардаг оюутнуудын 27.3 хувь, хамаатны гэрт амьдардаг оюутнуудын 40.8 хувь, оюутны байранд амьдардаг оюутнуудын 33.5 хувь, түрээсийн байранд амьдардаг оюутнуудын 32.5 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон байна.

Хүснэгт 3.34 Оюутан залуусын бэлгийн зан үйл, амьдардаг газраар

Үзүүлэлтүүд	Гэртээ, гэр бүлийн хамт	Гэртээ ганцаараа	Хамаатны гэрт	Оюутны байранд	Түрээсийн байранд
Бэлгийн хавьталд орж үзсэн эсэх					
Тийм	65.6	81.5	57.0	57.2	63.0
Үгүй	34.4	18.5	43.0	42.8	37.0
Анх бэлгийн хавьталд орсон нас					
16 хүртэл	9.0	13.6	10.9	11.8	5.5
16-20	80.8	86.4	76.9	79.9	77.2
20 ба түүнээс дээш	10.2	0	12.2	12.2	17.3
<i>Анх бэлгийн хавьталд орсон насны дундаж</i>	<i>17.5</i>	<i>16.8</i>	<i>17.6</i>	<i>17.4</i>	<i>17.6</i>
Бүгд	100	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	443	22	147	364	127
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон эсэх					
Тийм	79.5	68.2	80	77.5	87.6
Үгүй	19.9	31.8	19.3	22.3	12.4
Санахгүй байна	0.7	0.0	0.7	0.3	0.0
Бүгд	100	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	448	22	150	373	129
Сүүлийн 12 сарын хугацаанд бэлгийн хавьталд орсон хүний тоо					
1	75.7	66.7	74.8	68.1	74.8
2-4	7.5	13.3	23.5	28.7	24.3
5-аас дээш	1.7	20.0	1.7	3.2	0.9
<i>Дундаж</i>	<i>1.5</i>	<i>2.7</i>	<i>1.4</i>	<i>1.6</i>	<i>1.5</i>
Бүгд	100	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	346	15	115	279	107
Сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд орсон эсэх					
Тийм	27.5	27.3	40.8	33.5	32.5

Үгүй	72.5	72.7	59.2	66.5	67.5
Бүгд	100	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	433	22	142	373	126

Оюутнуудын бэлгэвчийн хэрэглээг хүйс, болон суралцдаг сургуулийн төрлөөр ангилан харахад нийт оюутнуудын 60 орчим хувь нь анх бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн, 50-60 орчим хувь нь сүүлийн тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн байна.

Хүснэгт 3.35 Оюутан залуусын бэлгэвчийн хэрэглээ

	Анх бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн %	Нийт хариулагчдын тоо	Хамгийн сүүлд тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн %	Нийт хариулагчдын тоо
Нийт	57.3	1127	57.4	455
Жинлэсэн % (95% ИХ)	57.3 (57.0-57.6)	92383	56.6 (56.1-57.1)	36971
Эрэгтэй	57.3	665	64.3	291
Эмэгтэй	57.4	462	45.1	164
Улсын сургууль	56.0	720	55.7	316
Хувийн сургууль	59.2	358	63.4	112
МСҮТ	63.3	49	51.9	27

Оюутнуудаас бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан шалтгаануудыг тодруулахад бэлгийн хавьтагчдаа итгэдэг, бэлгэвч байгаагүй, олдоогүй, хэрэглэхээ мартсан зэрэг шалтгаанууд хамгийн өндөр хувьтай байна.

Хүснэгт 3.36. Оюутан залуусын бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан шалтгаан

Бэлгэвчгүй бэлгийн харьцаанд орж байсан шалтгаан	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Бэлгэвч хэрэглэх дургүй	10.1	10.7	9.2
Бэлгэвч хэрэглэхээ мартсан	14.6	17.2	10.7
Бэлгэвч хэрэглэж байгаагүй учир мэдэхгүй	11.9	9.7	15.3
Тухайн үед бэлгэвч олдоогүй	15.8	20.3	9.2
Бэлгэвч авах цаг, зав гараагүй	6.2	8.3	3.1
Бэлгэвч үнэтэй	0.2	0.0	0.5
Бэлгэвч худалдаж авахад эвгүй, ичдэг	4.5	5.9	2.6
Би бэлгэвчинд итгэдэггүй	1.0	1.0	1.0
ХДХВ, БЗДХ-аас хамгаалах өөр арга мэддэг	1.4	1.7	1.0
Бэлгийн хавьтагч дургүйцдэг	2.5	2.1	3.1
Бэлгийн хавьтагчдаа би итгэдэг	28.6	24.1	35.2
Бэлгэвч надад байгаагүй	21.4	28.3	11.2
Би согтуу байсан	2.9	4.1	1.0
Хүчирхийлэлд өртсөн	0.6	0.3	1.0
Жирэмслэлтээс сэргийлэх өөр арга хэрэглэдэг	3.7	2.8	5.1
Намайг өвчтэй гэж боддог	0.6	0.7	0.5
Бусад	9.9	8.6	11.7
Нийт хариулагчдын тоо	486	290	196

Оюутнуудаас санхүүгийн тусламж үзүүлээд бэлгийн хавьталд орох санал авч байсан эсэхийг нь асуухад нийт оюутнуудын 92.8 хувь, эрэгтэй оюутнуудын 94.8 хувь, эмэгтэй оюутнуудын 91.2 хувь нь огт үгүй гэж хариулсан байна. Нийт оюутнуудын 65 хувь, эрэгтэй оюутнуудын 60.8 хувь, эмэгтэй оюутнуудын 67.9 хувь нь санхүүгийн тусламж үзүүлдэг бэлгийн хамтрагч байдаг гэдэгтэй санал нийлж байна.

Хүснэгт 3.37. Оюутан залуусын бэлгийн зан үйлийн талаарх хандлага, хүйсээр болон сургуулиар

Үзүүлэлтүүд	Нийт	Жинлэсэн % (95% ИХ)	Эрэгтэй	Эмэгтэй	Улсын сургууль	Хувийн сургууль	Коллеж
Санхүүгийн тусламж үзүүлээд бэлгийн хавьталд орох санал тавьж байсан эсэх							
Байнга	0.1	0.1 (0.08-0.12)	0.1	0.1	0.0	0.3	0.0
Ихэнхдээ	0.1	0.1 (0.08-0.12)	0.0	0.2	0.1	0.0	1.0
Заримдаа	2	2.1 (2.0-2.2)	1.4	2.6	1.9	2.2	1.9
Ховорхон	4.9	5.0 (4.9-5.1)	3.7	5.9	5.1	4.6	4.8
Огт үгүй	92.8	92.7 (92.6-92.8)	94.8	91.2	92.9	92.8	92.3
Санхүүгийн тусламж үзүүлдэг бэлгийн хамтрагч байдаг гэдэгтэй санал нийлж буй эсэх							
Бүрэн нийлнэ	45.4	45.7 (45.5-45.9)	41.8	48.5	45.4	42.7	60.6
Санал нийлнэ	10.4	10.4 (10.2-10.6)	10.7	10.2	10.1	10.8	11.5
Зөвшөөрч байна	9.2	9.2 (9.1-9.30)	9.2	9.2	8.7	10.8	5.8
Санал бага нийлнэ	27.5	27.4 (27.2-27.6)	29.1	26.1	28.6	26.8	18.3
Санал нийлэхгүй	7.5	7.4 (7.3-7.5)	9.3	6.0	7.2	8.9	3.8
Ижил хүйсийн хүнтэй бэлгийн хавьталд орох нь							
Энгийн үзэгдэл	2.4	2.4 (2.3-2.5)	2.2	2.6	1.9	3.3	2.9
Байж болно	9.8	10.0 (9.9-10.1)	7.4	11.8	9.9	9.9	6.7
Зөвшөөрч байна	4.1	4.1 (4.0-4.2)	3.8	4.4	4.3	4.1	1.9
Ховор тохиолддог	20.1	19.9 (19.7-20.1)	21	18.8	20.3	17.3	32.7
Огт зөвшөөрөхгүй	41.1	40.8 (40.6-41.0)	45.8	37.2	43	38.1	37.5
Мэдэхгүй	22.5	22.8 (22.6-23.0)	19.2	25.3	20.6	27.3	18.3
Бүгд	100	100	100	100	100	100	100
Нийт хариулагчдын тоо	1875	157138	863	1011	1187	583	104

Нийт оюутнуудын 16.3 хувь, эрэгтэй оюутнуудын 13.4 хувь, эмэгтэй оюутнуудын 18.8 хувь нь ижил хүйсийн хүнтэй бэлгийн хавьталд орох нь байж болох зүйл гэж үзэж байгаа бол нийт оюутнуудын 41.1, эрэгтэй оюутнуудын 45.8 хувь, эмэгтэй оюутнуудын 37.2 хувь нь огт зөвшөөрөхгүй гэж хариулсан байна. Улсын сургуульд суралцагсдын 7.1 хувь, хувийн сургуульд суралцагсдын 7.2, МСҮТ-д суралцагсдын

7.7 хувь нь санхүүгийн тусламж үзүүлээд бэлгийн хавьталд орох саналыг авч байжээ.

Санхүүгийн тусламж үзүүлдэг бэлгийн хамтрагч байдаг гэдэгтэй санал нийлж буй оюутнуудын тоо улсын сургуулийн хувьд 64.1, хувийн сургуулийн хувьд 64.3, МСҮТ-ийн хувьд 77.9 хувь байна.

Харин ижил хүйсийн хүнтэй бэлгийн хавьталд орохыг байж болох зүйл гэж үзэж байгаа оюутнууд улсын сургуульд суралцагсдын хувьд 16.1, хувийн сургуульд суралцагсдын хувьд 17.3 хувь, МСҮТ-д суралцагсдын хувьд 11.5 хувь байна. Улсын сургуулийн оюутнуудын 43 хувь, хувийн сургуулийн оюутнуудын 38.1 хувь, МСҮТ-ийн оюутнуудын 37.5 хувь нь ижил хүйсийн хүнтэй бэлгийн харьцаанд орох үзэгдлийг огт хүлээн зөвшөөрөхгүй байна.

3.2.4 Бэлгийн замаар дамжих халдвар

Нийт оюутнуудын 6.9 хувьд нь сүүлийн 12 сарын хугацаанд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн бол 46.9 хувь нь эмчлүүлсэн, эрэгтэй оюутнуудын 2.8 хувьд нь шинж тэмдэг илэрч 58.3 хувь нь эмчлүүлсэн, эмэгтэй оюутнуудын 10.5 хувьд нь шинж тэмдэг илэрч, 44.3 хувь нь эмчлүүлсэн байна.

Хүснэгт 3.38 Оюутан залуусын бэлгийн замаар дамжих халдвар

Үзүүлэлтүүд	Сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн %	БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн бөгөөд улсын болон хувийн эмнэлэгт эмчлүүлсэн %	Нийт хариулагчдын тоо
Нийт	6.9	46.9	1874
Жинлэсэн % (95% ИХ)	8.2 (8.1-8.3)	3.4(3.3-3.5)	157,138
Эрэгтэй	2.8	58.3	863
Эмэгтэй	10.5	44.3	1011
Улсын сургууль	6.6	38.5	1187
Хувийн сургууль	7.5	61.4	583
МСҮТ	7.7	50.0	104
Гэртээ, гэр бүлийн хамт	6.0	61.0	684
Гэртээ ганцаараа	14.8	50.0	27
Хамаатны гэрт	9.1	25.0	263
Оюутны байранд	6.1	35.7	687
Түрээсийн байранд	6.5	68.4	208

Улсын сургуулийн оюутнуудын 6.6 хувь, хувийн сургуулийн оюутнуудын 7.5 хувь, коллежийн оюутнуудын 7.7 хувьд нь БЗДХ-ын шинж илэрсэн ба хувийн сургуулийн оюутнуудын 61.4 хувь, МСҮТ-ийн оюутнуудын 50.0 хувь, улсын сургуулийн оюутнуудын 38.5 хувь нь эмчлүүлсэн байна.

Гэртээ ганцаараа амьдардаг оюутнуудын хувьд БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн оюутан хамгийн их байгаа ба 14.8 хувьд нь шинж тэмдэг илэрч 50.0 хувь нь эмчлүүлсэн байна. Харин гэртээ гэр бүлийн хамт амьдардаг оюутнуудын 6.0 хувьд нь БЗДХ-ын шинж тэмдэг илэрч, 61.0 хувь нь эмчлүүлсэн байна.

3.2.5 Архи, согтууруулах ундааны хэрэглээ

Нийт оюутнуудын 24.4 хувь нь архи, согтууруулах ундааг сард нэг удаа, 38.0 хувь нь жилдээ 1-2 удаа хэрэглэдэг бол, 34.0 хувь нь огт хэрэглэдэггүй байна. Архи согтууруулах ундааны хэрэглээ эрэгтэй оюутнуудын хувьд харьцангуй өндөр байгаа ба нийт эрэгтэй оюутнуудын 22.4 хувь нь архи, согтууруулах ундааг огт хэрэглэдэггүй бол, эмэгтэй оюутнуудын 43.9 хувь нь огт хэрэглэдэггүй байна.

Эрэгтэй оюутнуудын 41.8 хувь, эмэгтэй оюутнуудын 20.3 хувь нь бэлгийн харьцаанд орохын өмнө архи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн бол эрэгтэй оюутнуудын 3.8 хувь, эмэгтэй оюутнуудын 0.4 хувь нь мансууруулах бодис хэрэглэж үзсэн байна.

Хүснэгт 3.39 Оюутан залуусын архи, согтууруулах ундааны хэрэглээ, хүйсээр

Хорт зуршлын хэрэглээ	Нийт		Жинлэсэн % (95% ИХ)	Эрэгтэй		Эмэгтэй	
	Хувь	Тоо		Хувь	Тоо	Хувь	Тоо
Архи согтууруулах ундааны хэрэглээ							
Өдөр тутам	0.0	0	0.0	0.0	0	0.0	0
7 хоногт нэгээс дээш	0.5	9	0.5 (0.47-0.53)	0.8	7	0.2	2
Сард нэг удаа	24.4	458	23.4 (23.2-23.6)	37.4	323	13.4	135
Сард нэгээс дээш	3.0	57	2.9 (2.8-3.0)	4.4	38	1.9	19
Жилдээ 1-2 удаа	38.0	713	38.3 (38.1-38.50)	35.0	302	40.7	411
Огт хэрэглэдэггүй	34.0	638	34.9 (34.7-35.1)	22.4	193	43.9	444
Бүгд	100	1875	100.0	100	863	100	1011
Бэлгийн хавьталд орохын өмнө архи согтууруулах ундаа хэрэглэж байсан эсэх							
Тийм	33.9	305	32.9 (32.6-33.2)	41.8	238	20.3	67
Үгүй	66.1	595	67.1 (66.8-67.4)	58.2	332	79.7	263
Бүгд	100	900	100	100	570	100	330
Мансууруулах бодис хэрэглэж үзсэн эсэх							
Хэрэглэж үзсэн	2.0	37	1.8 (1.7-1.9)	3.8	33	0.4	4
Хэрэглэж үзээгүй	98.0	1838	98.2 (98.1-98.3)	96.2	830	99.6	1007
Бүгд	100	1875	100	100	863	100	1011

Архи, согтууруулах ундааны хэрэглээ МСҮТ-ийн оюутнуудын хувьд хамгийн бага байгаа ба МСҮТ-ийн оюутнуудын 51.9 хувь, хувийн сургуулийн оюутнуудын 35.8 хувь, улсын сургуулийн оюутнуудын 31.5 хувь нь архи, согтууруулах ундааг огт хэрэглэдэггүй байна.

Улсын сургуульд суралцагсдын 31.6 хувь, хувийн сургуульд суралцагсдын 38.1 хувь, МСҮТ-д суралцагсдын 36.8 хувь нь бэлгийн хавьталд орохын өмнө архи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн бол улсын сургуулийн оюутнуудын 1.8 хувь, хувийн сургуулийн оюутнуудын 2.6 хувь, МСҮТ-ийн оюутнуудын 1.0 хувь нь мансууруулах бодис хэрэглэж үзсэн байна.

Хүснэгт 3.40 Оюутан залуусын архи согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ ба бэлгийн зан үйлийн талаарх хандлага, суралцдаг сургуулиар

Хорт зуршлын хэрэглээ	Улсын сургууль		Хувийн сургууль		Коллеж	
	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
Архи согтууруулах ундааны хэрэглээ						
Өдөр тутам	0.0	0	0.0	0	0.0	0
7 хоногт нэгээс дээш	0.3	4	0.7	4	1.0	1
Сард нэг удаа	25.5	303	23.5	137	17.3	18
Сард нэгээс дээш	3.2	38	2.7	16	2.9	3
Жилдээ 1-2 удаа	39.4	468	37.2	217	27.0	28
Огт хэрэглэдэггүй	31.5	374	35.8	209	51.9	54
Бүгд	100	1187	100	583	100	104
Бэлгийн хавьталд орохын өмнө архи согтууруулах ундаа хэрэглэж байсан эсэх						
Тийм	31.6	182	38.1	109	36.8	14
Үгүй	68.4	394	61.9	177	63.2	24
Бүгд	100	576	100	286	100	38
Мансууруулах бодис хэрэглэж үзсэн эсэх						
Хэрэглэж үзсэн	1.8	21	2.6	15	1.0	1
Хэрэглэж үзээгүй	98.2	1166	97.4	568	99.0	103
Бүгд	100	1187	100	583	100	104

Гэртээ ганцаараа амьдардаг оюутнуудын хувьд архи, согтууруулах ундааны хэрэглээ хамгийн өндөр байгаа ба 29.6 хувь нь архи, согтууруулах ундааг огт хэрэглэдэггүй бол, гэртээ, гэр бүлийн хамт амьдардаг оюутнуудын 33.9 хувь, хамаатны гэрт амьдардаг оюутнуудын 33.5, оюутны байранд амьдардаг оюутнуудын 35.4, түрээсийн байранд амьдардаг оюутнуудын 31.2 хувь нь архи, согтууруулах ундаа огт хэрэглэдэггүй байна.

Мансууруулах бодис хэрэглэж үзсэн тохиолдол гэртээ ганцаараа амьдардаг оюутнуудын хувьд мөн хамгийн өндөр байгаа ба 7.4 хувь нь мансууруулах бодис хэрэглэж үзсэн бол гэртээ, гэр бүлийн хамт амьдардаг оюутнуудын 2.5 хувь, хамаатны гэрт амьдардаг оюутнуудын 1.1 хувь, оюутны байранд амьдардаг оюутнуудын 1.7, түрээсийн байранд амьдардаг оюутнуудын 1.3 хувь нь мансууруулах бодис хэрэглэж үзсэн байна.

Гэртээ, гэр бүлийн хамт амьдардаг оюутнуудын 36.1 хувь, ганцаараа амьдардаг оюутнуудын 44.4 хувь, хамаатны гэрт амьдардаг оюутнуудын 31.1 хувь, оюутны байранд амьдардаг оюутнуудын 31.4 хувь, түрээсийн байранд амьдардаг оюутнуудын 35.8 хувь нь бэлгийн хавьталд орохын өмнө архи, согтууруулах ундаа хэрэглэж үзсэн байна.

Хүснэгт 3.41 Оюутан залуусын архи согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ ба бэлгийн зан үйлийн талаарх хандлага, амьдардаг газраар

Хорт зуршлын хэрэглээ	Гэртээ, гэр бүлийн хамт		Гэртээ ганцаараа		Хамаатны гэрт		Оюутны байранд		Түрээсийн байранд	
	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
Архи согтууруулах ундааны хэрэглээ										
Өдөр тутам	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0
7 хоногт нэгээс дээш	0.4	3	0.0	0	0.0	0	0.4	3	1.4	3

Сард нэг удаа	23.1	158	40.7	11	22.1	58	24.3	167	29.8	62
Сард нэгээс дээш	3.2	22	0.0	0	0.8	2	3.6	25	3.8	8
Жилдээ 1-2 удаа	39.3	269	29.6	8	43.7	115	36.2	249	33.7	70
Огт хэрэглэдэггүй	33.9	232	29.6	8	33.5	88	35.4	243	31.2	65
Бүгд	100	684	100	27	100	263	100	687	100	208
Бэлгийн хавьталд орохын өмнө архи согтууруулах ундаа хэрэглэж байсан эсэх										
Тийм	36.1	123	44.4	8	31.1	38	31.4	96	35.8	39
Үгүй	63.9	218	55.6	10	68.9	84	68.6	210	64.2	70
Бүгд	100	341	100	18	100	122	100	306	100	109
Мансууруулах бодис хэрэглэж үзсэн эсэх										
Хэрэглэж үзсэн	2.5	17	7.4	2	1.1	3	1.7	12	1.4	3
Хэрэглэж үзээгүй	97.5	667	92.6	25	98.9	260	98.3	675	98.6	205
Бүгд	100	684	100	27	100	263	100	687	100	208

Мансууруулах бодис хэрэглэж байсан оюутнууд ихэвчлэн өвс хэрэглэж байсан ба ихэвчлэн татах, үнэртэх, сорох аргаар хэрэглэж байсан байна. Мөн нийт оюутнуудын 0.34 хувь буюу 4 нь мансууруулах бодис хэрэглэж байсан хүнтэй бэлгийн хавьталд орж байсан байна.

Хүснэгт 3.42 Оюутан залуусын мансууруулах бодисын хэрэглээ

Мансууруулах бодис хэрэглэсэн байдал	Нийт
Хэрэглэж үзсэн мансууруулах бодисын төрөл	
Ам	1
Газ	5
Каннабис	2
Мансууруулах бодисын төрөл	1
Өвс	26
Шавар	1
Мансууруулах бодис хэрэглэсэн арга, хэлбэр	
Үнэртэх, сорох	20
Зажлах	-
Татах	30
Уух	2
Булчин тариа	-
Судас тариа	-
Бусад	1
Бүгд	37

3.2.6 ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүртээмж

Нийт оюутнуудын 28.3 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэж байсан ба уг үзүүлэлт хүйсийн хувьд ялгаагүй байна. Харин шинжилгээ хийлгэх шийдвэр гаргалтын хувьд эрэгтэй оюутнуудын талаас их хувь нь сайн дураараа хийлгэж байсан бол эмэгтэй оюутнуудын 60 гаруй хувь нь шаардлага гарсны улмаас хийлгэж байсан байна.

Шинжилгээ хийлгэсэн оюутнуудын 7.4 хувь нь эерэг гэсэн хариу авч байсан бол эрэгтэй оюутнуудын 8.4 хувь, эмэгтэй оюутнуудын 6.5 хувь нь эерэг гэсэн хариу авч байжээ.

Сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдсан байдлаар эрэгтэй оюутнууд илүү өндөр байгаа ба нийт эрэгтэй оюутнуудын 38.1 хувь нь олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдсан байна. Оюутнууд ихэвчлэн сургалтанд хамрагдах болон бэлгэвч хүлээн авах зэргээр олон нийтийн үйл ажиллагаанд хамрагддаг байна.

Нийт оюутнуудын 49.8 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэх шаардлага гарвал хаана очихоо мэддэг ба энэ талын мэдлэг эрэгтэй оюутнуудын хувьд бага зэрэг өндөр буюу 51.0 хувь нь мэддэг, эмэгтэй оюутнуудын 48.8 хувь нь хаана очихоо мэддэг байна.

ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдалтын байдлаар улсын сургууль хамгийн өндөр байгаа ба 30.5 хувь нь халдвар илрүүлэх шинжилгээ өгч байсан бол хувийн сургуулийн оюутнуудын 24.9 хувь, МСҮТ-ийн оюутнуудын 20.8 хувь нь шинжилгээ өгч байсан байна. Оюутнуудын талаас их хувь нь шаардлага гарсны улмаас шинжилгээнд хамрагдаж байжээ.

Шинжилгээ өгсөн оюутнуудын хариу эерэг гарсан тохиолдол МСҮТ-ийн оюутнуудын хувьд хамгийн өндөр буюу 20.0 хувьтай байгаа бол улсын сургуульд суралцагсдын 7.1, хувийн сургуульд суралцагсдын 6.4 хувийнх нь шинжилгээний хариу эерэг гарч байжээ.

ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдалт МСҮТ-ийн оюутнуудын дунд хамгийн өндөр байгаа ба МСҮТ-ийн оюутнуудын 46.9, хувийн сургуулийн оюутнуудын 39.8, улсын сургуулийн оюутнуудын 32.0 хувь нь олон нийтийн үйл ажиллагаанд ихэвчлэн сургалтанд суух, бэлгэвч хүлээн авах зэргээр хамрагдаж байсан байна.

Улсын сургуульд суралцагсдын 50.2 хувь, хувийн сургуульд суралцагсдын 48.0 хувь, МСҮТ-д суралцагсдын 54.2 хувь нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх бол хаана очихоо мэддэг байна.

Хүснэгт 3.43 ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хүйсээр

Сонгосон үзүүлэлтүүд	Бүгд		Жинлэсэн % (95% ИХ)	Эрэгтэй		Эмэгтэй		Улсын сургууль		Хувийн сургууль		МСҮТ	
	Хувь	Тоо		Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэж байсан	143603												
Шинжилгээ хийлгэж байсан	28.3	485	28.3(28.1-28.5)	28.7	225	28.0	260	30.5	340	24.9	125	20.8	20
Шинжилгээ хийлгэж байгаагүй	71.7	1227	71.7 (71.5-71.9)	71.3	560	72.0	667	69.5	774	75.1	377	79.2	76
Бүгд	100.0	1712	100	100	785	100	927	100	1114	100	502	100	96
Шинжилгээ хийлгэх шийдвэр гаргалт	33743.0												
Сайн дураараа	47.1	190	46.5 (46.0-47.0)	55.6	105	39.7	85	45.0	137	45.5	45	40.0	8
Шаардлага гарсны улмаас	52.9	213	53.5 (53.0-54.0)	44.4	84	60.3	129	54.0	147	54.5	54	60.0	12
Бүгд	100	403	100	100	189	100	214	100	284	100	99	100	20
Шинжилгээний хариуг эерэг байна гэж хэлж байсан эсэх	40644.0												
Тийм	7.4	36	7.3 (7.0-7.6)	8.4	19	6.5	17	7.1	24	6.4	8	20.0	4
Үгүй	85.2	413	85.3 (85.0-85.6)	83.6	188	86.5	225	85.0	289	86.4	108	80.0	16
Хариугаа аваагүй	7.4	36	7.4 (7.1-7.7)	8.0	18	6.9	18	7.9	27	7.2	9	0.0	0
Бүгд	100	485	100	100	225	100	260	100	340	100	125	100	20
Сүүлийн 12 сард ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдсан эсэх	143603												
Тийм	35.1	601	34.9 (34.7-35.1)	38.1	299	32.6	302	32.0	356	39.8	200	46.9	45
Үгүй	64.9	1111	65.1 (64.9-65.3)	61.9	486	67.4	625	68.0	758	60.2	302	53.1	51
Бүгд	100	1712	100	100	785	100	927	100	1114	100	502	100	96
Хамрагдсан үйл ажиллагааны төрөл	107066												
Сургалт	80.0	481	80.4 (80.2-80.6)	76.3	228	83.8	253	76.7	273	84.0	168	88.9	40
Бүлгийн ярилцлага	4.2	25	4.1 (4.0-4.20)	4.3	13	4.0	12	3.4	12	5.5	11	4.4	2
Сайн дурын зөвлөгөө, шинжилгээ	11.5	69	11.5 (11.3-11.7)	11.7	35	11.3	34	14.0	50	7.5	15	8.9	4
Бэлгэвч, чийгшүүлэгч хүлээн авсан	23.3	140	22.3 (22.1-22.5)	34.4	103	12.3	37	24.2	86	25.0	50	8.9	4
БЗДХ-ын оношилгоо	4.8	29	4.8 (4.7-4.9)	5.0	15	4.6	14	6.5	23	2.5	5	2.2	1
Бусад	1.8	11	1.9 (1.8-2.0)	1.7	5	2.0	6	1.4	5	3.0	6	0.0	0
Бүгд		601			299		302		356		200		45
ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ өгөх бол очих газраа мэдэх эсэх	143603												
Мэднэ	49.8	852	49.7 (49.4-50.0)	51.0	400	48.8	452	50.2	559	48.0	241	54.2	52
Мэдэхгүй	50.2	860	50.3 (50.0-50.6)	49.0	385	51.2	475	49.8	555	52.0	261	45.8	44
Бүгд	100	1712	100	100	785	100	927	100	1114	100	502	100	96


ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

- Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн дунд тэмбүүгийн халдварын тархалт 24.5 хувь тодорхойлогдсон нь 2014 оны үеэс 4.7 пунктээр буурсан байна. Тэмбүүгийн халдварын тархалтын бууралт судалгааны бүх байршлуудад тодорхойлогдлоо. ЭБҮ-ийн дунд ХДХВ-ийн халдварын тохиолдол илрээгүй.
- Судалгаанд хамрагдсан ЭБЭ-ийн дунд тэмбүүгийн халдварын тархалт 9.2 хувь байгаа нь 2014 оныхоос 2.1 пунктээр нэмэгдсэн байна. Харин ХДХВ-ийн халдварын тархалт 2014 оныхоос 2.8 пунктээр буурч 9.2% болсон.
- Судалгаанд хамрагдсан оюутан залуучуудын дунд тэмбүүгийн халдварын тархалт 0.6 хувь, ХДХВ-ийн халдварын тохиолдол илрээгүй.
- ХДХВ-ийн халдвараас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж, үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүн амын эзлэх хувийг 2014 оны үетэй харьцуулахад ЭБҮ-ийн дунд 8.1 пунктээр буурч 25.3 хувь, ЭБЭ бүлэгт 0.7 пунктаар нэмэгдэж 55.6 хувь, оюутан залуучуудын дунд 21.3 хувь нь байна.
- Сүүлийн 12 сард төлбөртэй бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэж байсан гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь ЭБҮ бүлэгт 51.3 хувь болж 2014 оныхоос 5.6 пунктээр буурсан. Сүүлийн 12 сард тохиолдлын бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн ЭБҮ-ийн хувь 31.7% болж 2014 оныхоос 6.7 пунктээр нэмэгдсэн.
- Сүүлийн 12 сард бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэсэн ЭБЭ-ийн эзлэх хувь 2014 оныхоос 10.4 пунктээр нэмэгдэж 55.9% болсон байна. сүүлийн 12 сарын хугацаанд эрэгтэй хүнтэй бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэдэг ЭБЭ-ийн эзлэх хувь 2014 оны үеэс 15.3-аар нэмэгдэж 60.2% болсон байна.
- Оюутан залуучуудын дунд бэлгийн хавьталд орох бүрдээ бэлгэвч хэрэглэдэг хувь 57.4 байна.

ЗӨВЛӨМЖ


- Судалгааны бүлгүүдэд ХДХВ, тэмбүүгийн халдварын шинэ тохиолдлыг тодорхойлдог болох.
- Тэмбүүгийн халдварын тархалт ЭБҮ-ийн дунд тогтвортой хэмжээнд хүртэл буурахгүй, ЭБЭ-ийн дунд нэмэгдсэн, хоёр бүлгийн дунд урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хамрагдалт, ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх цогц мэдлэгийн түвшин буурсан зэрэгт үндэслэн эрсдэлт бүлгийн хүн амын дундах урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хамралтыг чанаржуулах, өргөжүүлэх шаардлагатай байна.
- 15-24 насны оюутан залуучууд нь нийт хүн амын бүлгийн төлөөлөл тул тус бүлгийн судалгааг 4 жил тутамд, түүврийг Улаанбаатар хотын их, дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвөөр хязгаарлахгүйгээр улсын хэмжээнд явуулж, асуумж болон ийлдэс судлалын судалгаанд хамруулах.

Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан ЭБЭ-ийн үрийн зураглал



Тайлбар

- Тэмбүүгийн сорил эерэг
- ▲ ХДХВ-ын сорил эерэг
- ⌘ Тэмбүү болон ХДХВ-ын сорил эерэг
- Тэмбүү болон ХДХВ-ын сорил сөрөг



Тайлбар

- Тэмбүүгийн сорил эерэг
- ▲ ХДХВ-ын сорил эерэг
- ⊠ Тэмбүү болон ХДХВ-ын сорил эерэг
- Тэмбүү болон ХДХВ-ын сорил сөрөг

Хавсралт 2. ЭБҮ-ийн дундах ХДХВ-ийн халдвартай байх магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр

Үл хамаарах хувьсагчид	ХДХВ-ын халдвартай байх магадлалын харьцаа								
	OR	95% ИХ	p-утга	AdjOR	95% ИХ	p-утга	All	95% ИХ	p-утга
Хүн ам зүйн үзүүлэлтүүд									
Нас									
15-24	1			1			1		
25-34	0.889	(0.523-1.509)	0.663	0.911	(0.535-1.551)	0.731	0.733	(0.408-1.318)	0.3
35 ба түүнээс дээш	1.062	(0.598-1.887)	0.836	1.017	(0.569-1.817)	0.956	0.736	(0.379-1.429)	0.365
Гэрлэлтийн байдал									
Байнгын бэлгийн хавьтагчтай	1			1			1		
Байнгын бэлгийн хавьтагчгүй	0.784	(0.472-1.302)	0.347	0.777	(0.468-1.292)	0.331	0.642	(0.376-1.097)	0.105
Нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд									
Боловсролын түвшин									
Бүрэн дундаас доош	1			1			1		
Бүрэн дунд	0.552**	(0.343-0.891)	0.015	0.568**	(0.349-0.927)	0.023	0.479***	(0.279-0.821)	0.007
Бүрэн дундаас дээш	0.565*	(0.290-1.102)	0.094	0.582	(0.296-1.146)	0.117	0.54*	(0.262-1.110)	0.094
Ажил эрхлэлтийн байдал									
Ажил эрхэлдэг	1			1			1		
Ажил эрхэлдэггүй	0.983	(0.561-1.720)	0.952	0.978	(0.558-1.714)	0.939	0.796	(0.442-1.432)	0.446
Суралцдаг	1.017	(0.328-3.151)	0.977	1.024	(0.330-3.179)	0.967	0.987	(0.288-3.385)	0.983
Харьяалал									
Улаанбаатар	1						1		
Бусад	0.775	(0.482-1.246)	0.292				1.023	(0.602-1.737)	0.934
Мэдлэг, эрсдэлт зан үйлийн үзүүлэлтүүд									
ХДХВ-ын талаарх мэдлэг									
Зөв мэдлэгтэй	1			1			1		
Мэдлэггүй	0.927	(0.514-1.672)	0.800	0.959	(0.529-1.737)	0.89	0.873	(0.472-1.615)	0.665
ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилсан сэргийлэх хөтөлбөрт хамрагдаж байсан эсэх									
Хамрагдаж байсан	1			1			1		
Хамрагдаж байгаагүй	0.970	(0.631-1.490)	0.888	1.039	(0.676-1.598)	0.86	1.133	(0.724-1.775)	0.584
БЗДХ-ын шинж тэмдэг илэрч байсан эсэх									
Илэрч байсан	1			1			1		
Илэрч байгаагүй	0.72	(0.467-1.109)	0.136	0.736	(0.476-1.139)	0.169	0.706	(0.438-1.136)	0.151
Бэлгэвчийн тогтмол хэрэглээ									
Байнга хэрэглэдэг	1			1			1		
Байнга хэрэглэдэггүй	1.056	(0.687-1.621)	0.805	1.004	(0.647-1.559)	0.986	0.909	(0.559-1.477)	0.699
Гадаадын иргэнтэй бэлгийн хавьталд орж байсан эсэх									
Орж байсан	1			1			1		

Орж байгаагүй	0.739	(0.328-1.665)	0.466	0.766	(0.339-1.730)	0.521	0.875	(0.375-2.043)	0.758
Архи согтууруулах ундааны хэрэглээ									
Байнга хэрэглэдэг	1			1			1		
Ер нь хэрэглэдэг	0.846	(0.544-1.316)	0.458	0.854	(0.548-1.330)	0.484	0.9	(0.561-1.443)	0.662
Огт хэрэглэдэггүй	0.425*	(0.158-1.141)	0.09	0.442	(0.164-1.190)	0.106	0.481	(0.157-1.475)	0.2

Хавсралт 3. ЭБЭ-ийн дундах ХДХВ-ийн халдвартай байх магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр

Үл хамаарах хувьсагчид	ХДХВ-ийн халдвартай байх магадлалын харьцаа								
	OR	95% CI	р-утга	AdjOR	95% CI	р-утга	All	95% CI	р-утга
Хүн ам зүйн үзүүлэлтүүд									
Нас									
15-24	1						1		
25-34	2.385*	(0.896-6.348)	0.082				2.519	(0.662-9.595)	0.176
35 ба түүнээс дээш	1.401	(0.477-4.120)	0.54				1.592	(0.373-6.801)	1.592
Гэрлэлтийн байдал									
Байнгын бэлгийн хавьтагчтай	1			1			1		
Байнгын бэлгийн хавьтагчгүй	1.135	(0.477-2.698)	0.775	1.361	(0.553-3.352)	0.503	1.246	(0.457-3.393)	0.667
Нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд									
Боловсролын түвшин									
Бүрэн дундаас доош	0			0			0		
Бүрэн дунд	0.617	(0.254-1.498)	0.285	0.807	(0.292-2.235)	0.68	0.702	(0.216-2.279)	0.556
Бүрэн дундаас дээш	1			1			1		
Ажил эрхлэлтийн байдал									
Ажил эрхэлдэг	1			1			1		
Ажил эрхэлдэггүй	1.811	(0.637-5.151)	0.266	2.05	(0.704-5.975)	0.188	2.629	(0.780-8.852)	0.119
Суралцдаг	1.015	(0.365-2.825)	0.977	1.709	(0.478-6.108)	0.41	1.67	(0.376-7.414)	0.5
Үндсэн харьяалал									
Улаанбаатар	1			1			1		
Бусад	1.323	(0.540-3.239)	0.54	1.443	(0.576-3.614)	0.434	1.824	(0.653-5.094)	0.251
Мэдлэг, эрсдэлт зан үйлийн үзүүлэлтүүд									
<i>ХДХВ-ийн талаарх мэдлэг</i>									
Зөв мэдлэгтэй	1			1			1		
Мэдлэггүй	1.504	(0.564-4.012)	0.415	1.561	(0.578-4.216)	0.38	2.333	(0.737-7.382)	0.149
ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдаж байсан эсэх									
Хамрагдаж байсан	1			1			1		
Хамрагдаж байгаагүй	1.043	(0.450-2.416)	0.922	1.128	(0.482-2.638)	0.782	1.355	(0.521-3.521)	0.533
БЗДХ-ын шинж тэмдэг илэрч байсан эсэх									
Илэрч байсан	1			1			1		
Илэрч байгаагүй	0.118***	(0.038-0.370)	0.000	0.123***	(0.039-0.391)	0.000	0.092***	(0.025-0.343)	0.000
Бэлгэвчийн тогтмол хэрэглээ									
Байнга хэрэглэдэг	1			1			1		
Байнга хэрэглэдэггүй	0.897	(0.377-2.133)	0.805	0.895	(0.373-2.147)	0.803	0.537	(0.191-1.504)	0.237
Гадаадын иргэнтэй бэлгийн хавьталд орж байсан эсэх									
Орж байсан	1			1			1		

Орж байгаагүй	0.556	(0.239-1.294)	0.173	0.656	(0.270-1.593)	0.352	0.479	(0.172-1.336)	0.16
Архи согтууруулах ундааны хэрэглээ									
Байнга хэрэглэдэг	1			1			1		
Ер нь хэрэглэдэг	1.088	(0.428-2.766)	0.86	1.277	(0.489-3.336)	0.617	1.978	(0.677-5.780)	0.212
Огт хэрэглэдэггүй	0.429	(0.050-3.671)	0.439	0.491	(0.056-4.267)	0.519	0.661	(0.061-7.129)	0.733

Хавсралт 4. 15-24 насны оюутан залуучуудын дунд ХДХВ-ийн халдвар тархахад нөлөөлөх хүчин зүйл

Үл хамаарах хувьсагчид	ХДХВ-ийн халдвартай байх магадлалын харьцаа						All	95% CI	p-утга
	OR	95% CI	p-утга	a.OR	95% CI	p-утга			
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд									
Гэрлэлтийн байдал									
Байнгын бэлгийн хавьтагчтай	1			1			1		
Байнгын бэлгийн хавьтагчгүй	0.446	(0.141-1.413)	0.17	0.445	(0.140-1.421)		0.547	(0.167-1.792)	0.319
Суралцдаг сургуулийн хэлбэр									
Төрийн өмчит	1						1		
Хувийн өмчит	0.451	(0.097-2.092)	0.309				0.438	(0.091-2.106)	0.303
МСҮТ	1.271	(0.159-10.129)	0.821				1.537	(0.179-13.182)	0.695
Амьдардаг газар									
Гэртээ гэр бүлийн хамт	1			1			1		
Гэртээ ганцаараа	5.223	(0.589-46.319)	0.138	5.134	(0.575-45.865)	0.143	4.615	(0.422-50.446)	0.21
Хамаатны гэрт	0.518	(0.060-4.458)	0.549	0.488	(0.056-4.209)	0.514	0.614	(0.052-7.327)	0.7
Оюутны байранд	0.795	(0.213-2.974)	0.734	0.732	(0.194-2.764)	0.646	1.046	(0.174-6.288)	0.961
Түрээсийн байранд	0.641	(0.074-5.513)	0.685	0.632	(0.073-5.473)	0.677	0.767	(0.064-9.261)	0.835
Үндсэн харьяалал									
Улаанбаатар	1			1			1		
Бусад	0.656	(0.207-2.075)	0.473	0.609	(0.190-1.952)	0.404	0.689	(0.131-3.631)	0.66
Мэдлэг, эрсдэлт зан үйлийн үзүүлэлтүүд									
ХДХВ-ийн талаарх мэдлэг									
Зөв мэдлэгтэй	1			1			1		
Мэдлэггүй	1.07	(0.321-3.567)	0.912	1.139	(0.334-3.891)	0.835	1.194	(0.331-4.310)	0.787
ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдаж байсан эсэх									
Хамрагдаж байсан	1			1			1		
Хамрагдаж байгаагүй	1.419	(0.383-5.262)	0.6	1.406	(0.378-5.236)	0.611	1.327	(0.341-5.175)	0.683
БЗДХ-ын шинж тэмдэг илэрч байсан эсэх									
Илэрч байсан	1			1			1		

Илэрч байгаагүй	0.369	(0.80-1.702)	0.201	0.362	(0.078-1.674)	0.193	0.485	(0.097-2.415)	0.377
Бэлгэвчийн тогтмол хэрэглээ									
Байнга хэрэглэдэг	1			1			1		
Байнга хэрэглэдэггүй	0.808	(0.176-3.708)	0.784	0.831	(0.181-3.819)	0.812	1.106	(0.234-5.237)	0.899
Архи согтууруулах ундааны хэрэглээ									
Байнга хэрэглэдэг	0			0			0		
Ер нь хэрэглэдэг	5.749*	(0.741-44.626)	0.094	5.86*	(0.749-45.863)	0.092	5.271	(0.660-42.901)	0.117
Огт хэрэглэдэггүй	1			1			1		
